

ИХ ШАВИЙН ОРЛОЙН МЭРГЭН ХУТАГТ

Г. БАЯРМАА

Товч агуулга: Халхын шашны тэргүүн Жибзундамба хутагтын харьяанд өөрийн орон хийд, отог шавийг захирах эрдэм мэдлэг, эрх ямба бүхий хутагтууд захирагдаж байсан билээ. Тэднийг Их шавийн голын долоон хутагт хэмээн нэрлэдэг. Эдгээр хутагт нь тамгагүй хутагтууд юм. Богд гэгээний голын долоон хутагтууд шашин номын үйлээрээ ихэд алдартай байсан бөгөөд тэдний дотроос эрдэм мэдлэг, улс төрийн үйл ажиллагаагаараа тодрон Монголын соёл, улс төрийн түүхэнд нэрээ мөнхөлсөн хутагт хувилгаад цөөнгүй байв. Тэдний төлөөлөл бол шашин төрийн зүтгэлтэн Манзушир хутагт Цэрэндорж, шашны зүтгэлтэн Орлойн мэргэн хутагт нар байсныг түүх гэрчилнэ. Голын долоон хутагтын түүхийн судалгаа нь зөвхөн долоон хүний асуудал биш олон үе хувиран төрсөн хутагтуудын түүх билээ. Гэтэл манай түүх бичлэгт хамтатгасан байдлаар тойм төдий авч үзсэн байдаг. Манзушир хутагт Цэрэндоржийн улс төрийн үйл хэргийн судалгааг эс тооцвол төдийлөн хийгдээгүй орхигджээ гэж хэлэхэд хилсдэхгүй. Эдгээр түүхэн зүтгэлтнүүдийн түүх намтрыг судлах нь Түүхийн шинжлэх ухааны хавсарга ухаан, Намтар судлалын салбарт төдийгүй, өмнөх үеийн түүх судлалын цагаан толбыг арилгахад зохих үүрэг гүйцэтгэнэ. Иймээс энэхүү өгүүлэлд Их шавийн голын долоон хутагтын нэг Дарьганга нутагт залагдсан Орлойн мэргэн хутагтын түүх, үйл хэргийг хэрхэн тодруулснаа өгүүлэх болно. Энд, Орлойн мэргэн хутагт Жибзундамба хутагтын шавьд хэрхэн захирагдсан, хийд орноо байгуулсан, тусгай отог шагнагдсан, Дарь овоог тахих үүргийг хүлээх болсон гэх хэсгүүдээр тодруулан үзэхийг зорилоо. Чингэхдээ Монгол Улсын Үндэсний Төв Архивын Түүхийн баримтын архив, Монголын Үндэсний Номын Сангийн Монгол судлал, гар бичмэлийн сан хөмрөг, Тагнуулын Ерөнхий Газрын Тусгай Архивын зохих баримтууд болон нутгийн ардын аман түүхийн эх сурвалжуудыг ашигласан болно.

Түлхүүр үг: Шарын шашин, Орлойн мэргэн хутагт, отог, шавь, сүм хийд

Удиртгал

Монголчууд Чин улсын захиргаанд орсон үеэс Манжийн хаад хутагт хувилгаадын асуудалд анхаарлаа хандуулж шат дараалсан ялгамжтай бодлогуудыг явуулж эхэлсэн байдаг. Халхууд Чин улсыг дагахад тодорхой үүрэг гүйцэтгэсэн Өндөр гэгээн Занабазарыг Энх-Амгалан хаан онцгойлон хандаж,

өргөмжлөн тэтгэсэн нь хожим хутагт хувилгаадын талаар баримтлах бодлогын үндэс болсон байна. Тухайлбал, хутагтуудын шавь нарыг улсын албанаас чөлөөлсөн, хошууны ардууд хутагтын шавьд чөлөөтэй шилжин суурьших, шавийн захиргаанд өөрчлөлт оруулалгүй хэвээр үлдээсэн нь бусад хутагтын шавийн захиргааны загвар болсон гэх мэт. Чин улсын эхний жилүүдэд Халхад Жибзундамба хутагтыг тойрсон шашны нэгдмэл байдал зонхилж байсан¹бол

¹ Өндөр гэгээн Занабазарын үйл ажиллагаагаар тайлбарлаж болохоор байна.

---XVII зууны дунд үе болоход Халхын баруун, зүүн гарын ноёд өөрсдийн гэрээс хутагт хувилгаадыг тодруулан тус тусын эзэмшилдээ тахилын лам болгон шүтэж байсныг судлаач Н. Хатанбаатар Монголын Хүрээ хийд лам нар (XVI-XX зууны эхэн) бүтээлдээ бичсэн байдаг. Халхын зүүн гарынхан Сэцэн ханы санаачлаг дэмжлэгээр Түшээт хан Гомбодоржийн хөвгүүнийг хутагтын ширээнд залсныг Өндөр гэгээний намтар зохиолуудад өгүүлсэн байдаг. Жибзундамба хутагт нь анх Сэцэн хан, Түшээт ханд тахигдсан хутагт байв.

---Засагт хан Норов 1662 онд нас барсны дараа Засагт хан аймагт хан ширээний төлөөх хямрал өрнөсөнд баруун гарын хутагтууд дотооддоо гарсан хямралын улмаас дайжин Жибзундамба хутагтыг түшиж ирсэн байдаг. Сурвалжид, ...Эрт урьд богд Сэцэн жононгийн үед нутагласан нутаг билээ. Түүний хойно Жонон тойн, Тэнгэр тойн эхлэн нутагласан нутаг бүлгээ. Тэр нутгаар нутаглаж сайхан суутал биднийг Засаг хаан, Жонон хоёр нутгаа нийлээд Жонон дүү нарынхаа улсыг аваад манд их ширүүн аашилж байна. ...Хааны үйлдсэн үйл нь дүүгээ Галдан хутагтын хүрээг цэргээр довтолж авав. Түүний хойно Манзушир хутагтын хүрээг цэргээр довтолж авав. ...Иймийн олон болсны тул долоон хошууны цаазаар баруун эвдэрвээс зүүндээ түших, зүүн эвдэрвээс баруундаа түших гэснээр Жибзундамба, Сайн хааныг түшсэн маань энэ гэжээ. (*Дайчин гүрний Дотоод яамны монгол бичгийн гэрийн данс*, IV боть, Улаанбаатар: Соёмбо, 2010,104) гэх мэт баримтууд байдаг. Мөн Зая бандид Лувсанпринлэй Лувсанчойжижалцанбогийн ердийн товч намтар зохиолд Өндөр гэгээний дотнын шавь нарыг дурдахдаа Жалханз Балжоржамцогийн хувилгаан Лувсанданзан, Очирдара шавдүнгийн хувилгаан Очирдара хутагт, Богд гэгээн Санжасанбугийн хувилгаан Далай Манзушир хутагт, Далай хутагт гэх мэт алтан ургийн язгууртнуудын гэрээс тодорсон хутагтууд Өндөр гэгээнийг түшиж, шавь болж явсныг тэмдэглэсэн байна. (Өндөр гэгээний намтрууд оршивой, Улаанбаатар: Шинжлэх ухаан академи, 1995, 23.)

---Анхдугаар Богд Өндөр гэгээн Занабазар Төвөдийн шарын шашны тэргүүн Далай лам, Банчэн-Эрдэнэ ламтай ойр харилцаатай, дэмжлэг тусламжийг авч байсан. V Далай лам Лувсанжамц, IV Банчин-Эрдэнэ Лувсанчойжижалцан нар Өндөр гэгээнийг Жонанба ёсны IV дүр Гунгаанинбогийн (1575-1634) хувилгаан мөн хэмээн тодруулсан. 1649 онд Төвөдөд очиж Банчэн-Эрдэнэ, Далай ламаар ном заалган 1651 онд нутагтаа буцахад V Далай лам түүнд Жибзундамба хутагт цол хүртээж, хүрээ хийдээ барьж байгуулах ажилд хүн хүчээр тусалж дэмжсэн гэх мэт. Энэ үйл явдлыг Доктор Д.Дашбадрах ...Халхын богдын нэр нөлөө өргөж алдаршуулах ...үйл хэрэгт Түвэдийн IV Банчин-Эрдэнэ Лувсанчойжижалцан (1570-1662) V Далай лам Лувсанжамц (1616-1682) зэрэг Түвэдийн нөлөө бүхий хутагтууд ч их идэвхтэй оролцож байжээ. Тэр үед хэн нэгэн хутагтыг тодруулахад Банчэн-Эрдэнэ, Далай лам нараас эрхбиш зөвшөөрөл соёрхол авдаг ёс Монгол Түвэдийн харилцаанд нэгэнт тогтон хэвшсэн тул Халхын ноёд Занабазарыг хутагтаар тодруулах тухай айлтгуулахаар Түвэдэд элч одуулсан. (Дашбадрах Д. *Монгол -Түвэдийн улс төр, шашны харилцааны түүх*, Улаанбаатар: 1998, 47.)

---Өндөр гэгээн Занабазар Халх Манж Чин улсын захиргаанд орох асуудалд тодорхой байр суурьтай оролцсон. Энэ тухай Өвөр монголын эрдэмтэн Чигэрэнхүү ...1689 оны Ар элстэйд чуулганд Халхын ноёд Өндөр гэгээн Занабазараас Чи ...гэгээн лам мину бидэнд нэг амар түвшин энх жаргалтай замыг зааж соёрхох болов уу гэж гэсэнд Дээд Жибзундамба хутагт тухайн үеийн цаг байдлыг задлан шинжилж “Умар зүгийн Орос хэмээх шар хятадын хаан төрийг хэдүй энх түвшин их гүрэн боловч тэнд бурханы ёс эс дэлгэрсэн бөгөөтөл хувцасны зах нь буруу тул тэнд одож үл болмой. Өмнө зүгийн хар хятад хаан төр болбоос энх түвшин бөгөөтөл бурхны ёс мөн асар дэлгэрчээ. Дахин хэлбээс Дайчин гүрний хааны хувцас нь үнэхээр тэнгэрийн хувцас мэт

1737 онд Тамгатай хутагтын шавийн захиргааг байгуулснаар Манжийн хаадаас Жибзундамба хутагт болон Их шавийн захиргаатай ижил эрх хэмжээ бүхий тус тусын үйл ажиллагаагаа эрхлэн мэдэх засаг захиргааны нэгжийг буй болгосон байна.² Ингэхдээ шинэ байгуулагдсан Сайн ноён аймагт анхлан байгуулжээ. Энэхүү захиргааг эхэндээ Түшээт хан, Сэцэн хан, Засагт хан аймгуудад байгуулсангүй. Хожим 1821 онд Засагт хан аймгийн Ялгуусан хутагтын IV дүр Лувсансамдүвт, 1824 онд Жалханз хутагтын IV дүр Лувсанбалжирлхүндэвт, 1853 онд Бигэр Номун хан хутагтын III дүрийн Ишданзанд, 1868 онд Сэцэн хан аймгийн Егүзэр хутагтын III дүрийн хувилгаан Лувсанданзаннамжилд тус тус тамга шагнаснаар 11 тамгатай хутагтын захиргааг буй болгосон байдаг.

Манжийн Тэнгэрийн тэтгэсэн хаан 1762 онд хутаг хувилгаадыг тодруулан залах тусгай нарийн журам тогтоож,³ алтан ургийн язгууртны гэр бүлээс хувилгаан тодруулахыг явдлыг хориглосон байна. Уг шийдвэрийг 1789 онд

эд агуурс нь тэнгэр луусын эд эрдэнэсийн зүйл бүрдсэн их буянт хаан мөн болой. Хэрвээ тэр зүгт одвоос төр тогтож хамаг амьтан жаргал эдлэх болмой” гэж айлтгав. Халхын олон ван болон тайж нарыг Жибзундамба хутагтын энэхүү эрс шуурхай саналыг санал нэгтэй хүлээн авсан. (Чигэрэнхүү. *Жибзундамба хутагтын товч намтар*. Өвөр Монгол: Ардын хэвлэлийн хороо, 1992, 53.) Галдан, Эрдэнийн эрих хэмээх түүх болой ...Чахундорж хан Хөл хэмээх газраас говийг өнгөрч Жибзундамба хутагт лугаа нийлж хэлэлцэн Жибзундамба хутагтын гэгээн бээр цаг хүрснийг айлдаж Халх нар лугаа хэлэлцэж, дагаж орох учир мэдүүлсэн ...Өөлд ирж миний сүмийг гал тавьж, номыг сүйтгэж эвдэж дуусгав. ...Миний шавь нар маш олон Богд эзний энх төрд түшиж аж төрвөөс, миний санасан санаа гүйцэтгэмүй. Өндөр гэгээний тавин дөрвөн насны шар луу жил Халхын Түшээт хан Чахундорж нар Халхыг дагуулж, есөн цагаан барьж, Шэнцзу өршөөлт хуандийн төрийг тулгар түшиж, даган оров. (Галдан. *Эрдэнийн эрих хэмээх түүх болой*, Улаанбаатар: Соёмбо, 2015, 236.)

---Чин улсын хаад Өндөр гэгээн Занабазарыг Чин улсын захиргаанд орох хэрэгт тодорхой үүрэг гүйцэтгэснийг үнэлж Халхын шашны тэргүүн, Төвөдийн Далай лам, Банчин-Эрдэнэ лугаа ихээхэн блам хэмээн өргөмжилсөн. Сурвалжид, ...Живзундамба хутагтыг туслан, их лам болгон өргөмжилж, шарын шашныг бариулав. (Галдан. *Эрдэнийн эрих*. Улаанбаатар: Соёмбо, 2006, 207.) Баруун Зуугийн Далай лам, Банчин эрдэнийг дэслэн үеийн үед Халх дахины их ширээнд суух, их лам багш болгон өргөмжлөөд, ...Харагчин туулай (1723) жил Шицзун төлөвт хуандийн хишиг шашныг мандуулах, Живзундамба лам хэмээн алтан навчит өргөмжлөл, алтан тамга (Галдан, Эрдэнийн эрих, Улаанбаатар: 2006, 213.) олгохын сацуу улсын зардлаар сүм хийд байгуулах, ном судар хэвлэх, шавь ардыг алба татвараас хөнгөлөх зэргээр тэтгэн дэмжих бодлогыг хэрэгжүүлсэн байдаг. Энэ нь Халхын шашны тэргүүн гэдгийг баталгаажуулсан хэрэг байсан.

---Өндөр гэгээн Занабазар Халхад хамгийн анх шашны төвлөрсөн хүрээ хийдийн бүтэц зохион байгуулалт, тогтсон хурал номын дэг ёс, шавь нарын захиргааг буй болгосон. Энэ үйл хэрэгт Ламын гэгээн Лувсанданзанжанцан, Зая бандида Лувсанпрэнлэй зэрэг хутагтууд хамтран ажиллаж байв. Тухайлбал, Ламын гэгээн Лувсанданзанжанцан төвдөөс ирсний дараа Их хүрээний Хамба номун ханы албыг хашиж байсан гэх мэт

Халхуудын Чин улсад дагаар орохоос өмнөх Халхын улс төрийн нөхцөл байдал, дагаар орсны дараа Энх-Амгалан хаанаас Өндөр гэгээнд Занабазарт үзүүлсэн өргөмжлөн тэтгэх бодлого нь Халхад шашин нэгдмэл байх боломжийг олгож байсан болов уу?

² Энэ тухай миний бие 2020 онд Халхад тамгатай хутагтын шавийн захиргаа байгуулагдсан нь (Эрдэнэ бандида хутагтын шавийн жишээн дээр) өгүүллийг *Нүүдэлчийн өв судлал* Tom XXI II. Fas 15-д хэвлүүлсэн билээ.

³ Пүрэвжав, С., *Монгол дахь шарын шашны хураангуй түүх*, Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1978, 94.

Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамны хууль зүйлийн бичигт оруулан хуульчилсан. Ингэхдээ тухайн хутагтын дараа дүр байж болох сонгогдсон хөвгүүдийн нэрсийг алтан бумбад хийж, нэр нь сугалагдсан хөвгүүн хувилгаан болдог байв. Үүнийг шавга татна гэдэг. Хуульд *...Монгол олон аймгийн дэлгэрсэн хувилгаан Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яаманд өргөн мэдүүлж Гадаад Монголын төрийг засах явдлын яамны тэнхимийн түшмэд бламын тамга барьсан хутагт лугаа нийлж нэрийн шавга бичээд Найралт найрамдах ордонд тахиглах алтан бумба хувинд оруулж бүгдээр хамт нэгнээ татаж тогтоогтун*⁴ хэмээсэн ёсоор шавга татан тодруулах болжээ. Энэ үйл явц нь хутагтуудыг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн хэрэг байв.

1876-1879 онд Монгол нутгаар аялсан Хаант Оросын судлаач А.М.Позднеев Халхад төрөл аван төрөх хутагт 118 байна гээд Эрдэнэ шанзудбын яаманд бүртгэлтэй 44 хутагт⁵ байсныг номдоо оруулсан бол “Зарлигаар тогтоосон олон аймгийн тамга бүхий, үгүй хутагт хувилгаан нарын шастир”⁶ зохиолд Жибзундамба хутагт тэргүүтэй 67 хутагт бүртгэгджээ. Эдгээр хутагтуудаас Чингийн үед албан ёсоор шавга татан тодорсон нь Жибзундамба хутагт, 11 тамгатай хутагт, Их шавийн голын долоон хутагт нар байжээ.

Монгол Улсын шастирт тэмдэглэснээс үзвэл: *“Их шавийн урьд шавга татуулсан ба үгүй, тамга бүхий, үгүй хувилгаан”*⁷ хэмээн ангилан ялган шалгаж бичсэнээс үзэхэд шавга татуулалгүйгээр хувилгаан тодруулж байсан бололтой байна. Гэхдээ цаашид бүх хувилгаан хутагтуудыг шавга татан тодруулдаг байсан эсэхийг нягтлан үзүүштэй бөгөөд хэрэв татуулан тодруулдаггүй байсан бол өөр ямар аргаар тодруулж байсныг судлан үзэж, тодруулах шаардлага байна.

Хууль ёсоор тодорсон хутагтуудын үндсэн үүрэг нь *...Дотоод гадаад засгийн олон газрын хутагт, хувилгаан, цорж блам, тэргүүн блам нар насанд хүрч бие боловсорсныг нь нийслэл хотод ирүүлж бараалхуул. Номд боловсорт ол сурсныг нь түнли ном унших жасаанд зохион оруул. Түнли ном унших жасааг зургаан жасаа болгон тогтоож жил дараалан жасаалж өвлийн дунд сарын аравдаар нийслэл хотод ирүүл. Насанд хүрсэнгүй бие түүхий жич жасаа эс тохиолдсоныг нь монгол ван гүнгийн хууль ёсоор хүн зарж амгаланг эрж алба хүргээр ир. Уул жасаанд тохиолдож өвдсөн зэргийн учир бүхий нь болбоос харьяат чуулганы даргад тодорхойлон мэдүүлж харьяат чуулганы даргын газраас байцааж үнэн болбоос Журганд мэдүүлсний хойно, хойт жилийн жасаа нөхүүл. Хэрэв учиргүй жасааг хийлэх ба жич жил жилээр шалтаглаж үл ирэх нь болбоос харьяат хутагт блам нарын цолыг байлга. Басхүү харьяат чуулганы дарга засгуудыг байцаахыг алдсан хууль ёсоор ял хэлэлцэгтүн*⁸ хэмээн журамласнаар Дээдийн

⁴ ГМТЗЯЯХЗБ-ийн 58-р дэвтэр, Лам нарын хэргийн хууль (гуравдугаар), Хувилгаан заах тогтоосон хууль, Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл. I боть 1206-1910, Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2010, 484.

⁵ Позднеев.А.М, Монгол дахь буддын сүм хийд, лам хуврагуудын аж байдал, лам нар, ард иргэдийн харилцааны тухай тэмдэглэл, орч. Б. Гэрэл Улаанбаатар: Эрдэм Гэгээрэл Паблшинг, 2023, 233-236.

⁶ Монгол улсын шастир (дэд дэвтэр), Улаанбаатар: Соёмбо, 2006, 319-385.

⁷ Монгол улсын шастир (дэд дэвтэр), Улаанбаатар: Соёмбо, 2006, 387-399.

⁸ ГМТЗЯЯХЗБ-ийн 57-р дэвтэр, Лам нарын хэргийн хууль (хоёрдугаар), Дотоод, гадаад засгийн

түмэн өлзий бататгахын тухай Найралт найрамдах ордон ирж⁹ ном унших үүрэг хүлээх болсон ба энэ үйл явдлыг Түнли ном унших жасаа ирэх гэдэг.

Жибзундамба хутагтын шавь нар Халхын Сэцэн хан, Түшээт ханы нутгаар ихэвчлэн нутагладаг байв. Хутагтын шавьд Сэцэн хан, Түшээт хан аймгуудад шүтэгдсэн эрдэм чадал, эрх ямба бүхий Энэтхэг, Төвөд, Монголд олон үе хувилан төрсөн Донхор хутагт, Ялгуулсан хутагт номун хан, Эрдэнэ хамба номун хан, Мэргэн хамба номун хан, Эрдэнэ мэргэн бандида номун хан, Бамбар хутагт, Орлойн мэргэн хутагт гэх долоон хутагт харьяалагдан захирагдаж байсан. Тэд хэрхэн Жибзундамба хутагтын Их шавьд захирагдах болсныг:

1. Жибзундамба хутагт бол анхнаас Түшээт хан, Сэцэн хан аймагт тахигдсан хутагт байсан.
2. Чин улсын захиргаанд орсноор Сэцэн хан, Түшээт хан аймагт шүтэгдэж байсан хутагтууд Халхын шашны эзэн Жибзундамба хутагтын шавьд харьяалагдан захирагдсан нь аль нэг хошуунд тахигдсан хутагт байснаас илүү нэр хүндтэй, албан ёсоор хүлээн зөвшөөрөгдөх боломж байсан.
3. “Толын долоон хутагт”-ын Монголд тодорсон анхны дүрүүд I, II Богдуудын үед төрж, хувилгаан тодорч багш шавь бололцон хамтран шашин дэлгэрүүлж байсан байдаг. Тухайлбал, Донхор хутагт Агваанжамбалданзан Их хүрээний газар ирж, Жибзундамба хутагт лугаа учирсан, ...Энх-Амгалангийн үед Богд гэгээнд бараа болж манжийн хаанд бараалхаж, амгалан эрж хишиг¹⁰хүртэж явсан ба хожим II Богд Лувсандамбийдонмид ...Найралт төвийн 6 он (1728) шар шороон бичин жил ...гэнэн сахил¹¹-ийг хүртээн ёнзон багш нь болж, Их хүрээний анхны гүн ухааны дацанг 1736 онд байгуулж хамтран шашин номын үйлийг эрхэлж байсан байдаг. Бусад хутагтууд шавьд захирагдсан нь тодорхой бус ч Зая бандида Лувсанпрэнлэйн, Өндөр гэгээн Занабазарын дотнын шавь нарын дунд *Дашлхүнбийн шавь Мэргэн номун хан, Мэргэн номун ханы хувилгаан Равдан, Мэргэн бандида Равжамба, хувилгаан Эрдэнэ хамба номун хан, Хувилгаан бандида номун хан, Брэйбүн гоман ламын хувилгаан Ялгуусан хутагт, хувилгаан Эрдэнэ ялгуусан хутагт*¹²гэх хувилгаан хутагтууд байсныг тэмдэглэжээ. Мэргэн 3, Ялгуусан 2, Эрдэнэ, Номун хан цолтой хэд хэдэн хутагт, хувилгаад байгаагийн дотор миний сонирхож буй хутагтууд байхыг үгүйсгэх аргагүй. Тухайлбал, Төвөд оронд 4 удаа хувилгаан гарсан Ялгуусан хутагт номун ханы Монголд

олон газрын хутагт нар Нийслэл хотод бараалахаар ирсэн, *Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл*. I боть 1206-1910, Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2010, 478.

⁹ Юн Хэ Гүн буюу Найралт Найрамдах сүм 1694 онд буюу Манж Чин гүрний Энх-Амгалан хааны 33-р онд байгуулагджээ.

¹⁰ *Монголын сүм хийдийн түүхээс* ... (Баримт бичгийн эмхэтгэл), эмх Б.Эрдэнэбилэг, Улаанбаатар: ТЕГ-ын хэвлэх, 2014, 92.

¹¹ *Монгол улсын шастир* (дэд дэвтэр), Улаанбаатар: Соёмбо, 2006, 423.

¹² Зая бандид Лувсанпринлэй. *Живзундамба Лувсандамбижалцанбалсанбогийн ердийн товч намтар, Өндөр гэгээний намтрууд оришвой*, Түвэд хэлнээс орч. Ш.Бира, Улаанбаатар: ШУА, 1995, 23.

мэндэлсэн анхдугаар дүр Нямбуудоржийг (1672-1735) ...бага наснаас нь Өндөр гэгээн өөрийн хүү мэт энхрийлэн өсгөсөн¹³ гэснээс үзвэл Ялгуулсан цолтой 2 хутагт байгаагийн нэг нь байх боломжтой хэмээн би бээр үзэж байна. Өөрөөр хэлбэл голын долоон хутагтын анхны дүрүүд Анхдугаар богд Жибзундамба хутагттай нэгэн үед амьдарч, эрдэм номд суралцан шашин номыг дэлгэрүүлэхийн сацуу шавь орж байсан, мөн Жибзундамба хутагтуудад багшлах, хутагтын хүрээний хувраг шавь нарыг тэргүүлэх ажиллах болсон зэрэг шалтгаанаар Их шавь захирагдах болсон байж болох юм.

Их шавийн голын долоон хутагтын судалгааг 2004 онд доктор Дашбадрах Монголын хутагтуудын намтрын ойллого номын *Жибзундамба хутагтын харьяат шавийн голын долоон хутагт* бүлэгт хутагт тус бүрээр намтарчлан бичсэнээс хойш нэгдсэн байдлаар хийгдсэн судалгаа үгүй байна. Тэрээр тус номдоо ...Голын долоон хутагтын өөр өөрийн уг эх, хувилгаан гарсан, Их Хүрээний Хамба номун хамбаар болон дэд ламаар талбисан, жанч халсан байдлыг зүйл дараалан товч өгүүлэхдээ тэдний эрхэлж асан сүм дацан, отгийнх нь өрх, шавийн бүртгэлийн тоо баримтыг дурдахдаа төдий л нягталж амжаагүй болохыг анхаарна уу¹⁴ хэмээн өгүүлсэн байдаг. Мөн Их шавийн судалгааг хийж бүтээл туурвилаа гаргасан Ө.Сэрээтэр, З.Нинжбадгар, Н.Хатанбаатар¹⁵ нар сүм хийд, алба татвар, Их шавийн Хамба номун хан зэрэг олон асуудлуудыг тодруулж өгсөн боловч голын долоон хутагтуудын түүхийг тухайлан авч үзсэнгүй ээ.

Иймээс түүхч Дашбадрахын эхлүүлсэн судалгааг цаашид дэлгэрүүлэн хөгжүүлэх шаардлага байгааг харгалзан үзэж энэхүү өгүүллийг бичлээ.

Их шавийн харьяат долоон хутагтын харьяа сүм хийд хэрхэн байгуулагдаж байсан, шавьд хэрхэн захирагдсан, отог шавь нараа хэрхэн захирдаг байсан зэргийг асуудлыг Орлойн мэргэн хутагтын жишээгээр тодруулахдаа:

- Орлойн мэргэн хутагтууд
- Хутагтын хүрээний байршил ба сүм хийд лам нар
- Мэргэн хутагтын хүрээний хурал ном
- Орлойн мэргэн хутагтын харьяа отог шавь
- Дарь овоог тайх хэргийн тухайд гэх хэсгүүдэд хуваан үзлээ.

1. Орлойн мэргэн хутагтууд

Жибзундамба хутагтын харьяат Дарьганга нутагт тахигдсан хувилгаан бол Орлойн мэргэн хутагт юм. Чингийн үед манжийн хааны төмөр сүргийг Дарьгангын нутагт байгуулсан бөгөөд уул газар орон Чингийн хааны шууд

¹³ Монголын сүм хийдийн түүхэн товчоо, Улаанбаатар: Адмон, 2009, 132.

¹⁴ Дашбадрах Д. *Монголын хутагтууд, Монголын хутагтуудын намтрын ойллого (XVII-XX зуун)*, Улаанбаатар: 2004, 158.

¹⁵ Сэрээтэр Ө. *Монголын Их хүрээ, Гандан хийдийн түүхэн бүтцийн товч (1651-1938)*, Улаанбаатар: Адмон, 2017. Нинжбадгар З. *Жибзундамба хутагтын шавийн захиргаа (XVII-XX зууны эхэн)*, Улаанбаатар: Арвин судар, 2014. Хатанбаатар Н. *Монголын хүрээ хийд, лам нар (XVII-XX зууны эхэн)*, Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2018.

мэдлийн газар байсан билээ. Дарьгангын 5 гарын сүрэгчин (баруун болон зүүн гар адуучин, баруун болон зүүн гар тэмээчин, хонин сүрэг-Г.Б.) нарыг бүгдийн дарга захирдаг байв. Энэхүү онцгой бүс нутагт ард олноо ихэд хүндэтгэгдсэн хувилгаан бол Орлойн мэргэн хутагт байсан байдаг. Орной¹⁶ (Орлойн) гурван зээрд хэмээх өргөн тал нутгаар нэрийдсэн уг хутагтын шавь нар *...Дарьганга нутгийн хойд зүгт нутаглан харьяалан захирсан Эрдэнэ шанзудба нарын газраас 800 илүү газар алслагдан*¹⁷ оршиж байжээ.

Орлойн мэргэн хутагтуудын түүхийг өгүүлэх хэд хэдэн сурвалж бидний үед хадгалагдаж иржээ. Эдгээр сурвалжуудад хувилгаан дүрүүдийг зөрүүтэй тэмдэглэсэн байна. “Зарлигаар тогтоосон олон аймгийн тамга бүхий, үгүй хутагт хувилгаан нарын шастир”¹⁸ зохиол, “Богдын шавийн долоон хутагтын уг эх Жибзундамба хутагтын харьяа шавийн Донхор хутагт зэрэг долоон хутагт хувилгаан лам нарын өөр өөрийн уг эхийг зүйл дараалан байцаасан цэс”¹⁹ сурвалжуудад

I дүр хувилгаан Лувсангэлэг (1737-1788)

II дүр хувилгаан Лувсанжигмэддорж (1790-1853)

III дүр хувилгаан Дондовбал (1855-1889)

IV дүр хувилгаан Ринчинбадам (1889-193?²⁰) гэх дөрвөн дүр хувиан төрсөн тухай өгүүлжээ. Харин ТЕГ²¹-ийн тусгай архивд Уулбаян сумын Өглөгч бадруулагч (Жинбадаржаалин хийд-Г.Б.) гэх нэгэн баялаг мэдээ агуулсан баримтад таван үе хувиан төрсөн, анхдугаар дүрийн хувилгаан Лувсанжамбал²² гэж тэмдэглэжээ. Дөрвөн үе хувиан төрсөн тухай өгүүлэх баримтууд нь хутагтын уг эх гавьяа шагналыг тэмдэглэсэн бол ТЕГ-ийн баримтад сүм хийд байгуулагдсан түүхийг бичсэн байна.

Ингээд эх сурвалжуудыг ажиглаваас мэдээлэл зөрүүтэй байна. Энд, Хутагтын дөрвөн дүр тодорсон уу, таван дүр тодорсон уу гэдгийг тодруулан үзлээ. МҮТА-т буй Дарьганга сүргийн газарт Ганжуур ном унших, газар орны Дарь овоо тайх зэрэг хэргийг тэргүүлсэн хувилгаан Жигмэддоржийн уг эх, түүний бие харьяат газраас хэдэн газар бөглүү алслагдсан, одоо хэдэн шавь нар хураан цугларсан байдлыг байцаасан цэс гэх баримтад *...Тэнгэр тэтгэсний хорин гуравдугаар он (1758) Дарьгангын сүргийн түшмэл, цэрэг, лам, хар ард бүгдээр зөвлөлдөн, Халхын хоёрдугаар богд Жибзундамба хутагтаас харьяат сүргийн хувилгаан*

¹⁶ Архив баримт бичгүүдэд Орной гэж бичигддэг боловч нутгийнхан Орлойн хэмээн ярьж хэвшжээ. Иймээс тус өгүүлэлд архивын баримтаас ашиглахдаа Орной, бусад тохиолдолд Орлойн хэмээн бичлээ.

¹⁷ *Дарьгангын түүхэнд холбогдох баримтууд* (Баримт бичгийн эмхэтгэл), эмх.Т.Билэгсайхан, Улаанбаатар: Соёмбо, 2020, 60.

¹⁸ Монгол улсын шастир (дэд дэвтэр), Улаанбаатар: Соёмбо, 2006.

¹⁹ Богдын шавийн долоон хутагтын уг эх, МҮНС, Монгол судлал гар бичмэлийн сан хөмрөг, 36/96.

²⁰ Жанч халсан он нь тодорхойгүй байдаг.

²¹ Тагнуулын Ерөнхий газар ---ТЕГ гэж товчлов.

²² *Монголын сүм хийдийн түүхээс ...*(Баримт бичгийн эмхэтгэл), эмх Б.Эрдэнэбилэг, Улаанбаатар: ТЕГ-ын хэвлэл, 2014, 174.

*Дарь овоог тайлгах хэргийн дээр өгөх ном судар боловсон сайн лам гуйсанд, уул шавь Мэргэн Нансо-гийн хувилгаан Гэлэгийг тусгайлан гаргаж сүргийн газар залжээ. Иймд харьяат олон яам шавь нар шударга төрийг сахиулан ном уншуулах, одоо хувилгаан Дарь овоог тайлгах зэрэг хэргийг цөм түүнд даатгав*²³ хэмээн өгүүлэх бол Илтгэл шастир зохиол ...*Тэнгэрийг тэтгэсний 13 онд (1748) Цахар газар буй Манжийн хааны төмөр сүргийг захирсан дарга нарын газраас II Богд Жибзундамба хутагтад айлтган мэдүүлж, лам Лувсангэлэг хувилгаан өргөмжлөн Дарьгангын газраа ном уншуулахаар суулгажээ*²⁴ гэжээ. Хоёр баримт агуулгын хувьд ижил байгаа ч он цагийг зөрүүтэй байдлаар тэмдэглэжээ. Дээрх хоёр мэдээний 1758 онд гэх архивын баримтын он зөв болов уу? Баримтыг IV хутагт Жигмэддоржийн үед бичжээ. Харин Илтгэл шастир зохиолыг хожим XX зууны эхэнд нөхөн бичсэн магадгүй оныг алдаатай тэмдэглэсэн байж болно.

Баримтад өгүүлэгдэх Мэргэн Нансо-гийн хувилгаан хэмээсэн нь Дарьгангад хурал ном үүсгэсэн Лувсанжамбалыг хэлж байгаа бололтой. Тэрээр ...*1733 онд шавийн Өгөөмөр гэх газарт хувиас эсгий гэр хоёрыг барьж, мөн нутгийн лам нар болох долоон ламыг хуралдуулан, ...энэ газар 12 жил суурьшин байгаад усгүй болсон учраас 1745 онд өөр газар*²⁵ нүүдэллэсэн хэмээжээ.

1748 онд хутагт ...*нутгийн олон ардын тусламжтай Их хүрээнээс нэг чи хэмжээтэй Чойжил бурхныг залж, Ламиран дацан байгуулж Их хүрээний Агваанчойдог ламыг авчран дацангийн хурлыг дэглүүлэн, дөрвөн цагийн ламиранг тус бүр арван өдөр хурж, жилд нэг удаа Чойжил сахиусыг нэг өдөр хурахаар тогтмол болгож мөнхөлжээ*²⁶ гэснээс үзвэл Дарьганга дахь уг хийд Их хүрээний лам нартай хамтран ажиллаж, сүм хийдийнхээ хурал номыг Их хүрээний адил дэглэх болжээ.

Их хүрээний лам нартай ойр харилцаатай байсан сүм хийдийнхэн Бүгдийн дарга тэргүүтэнтэй зөвлөлдөж II Богдоос Дарь овоог тайлах хэргийг тухайд Дарьгангын газар ном уншуулах лам гуйсанд Мэргэн Нансо-гийн хувилгаан Гэлэгийг хувилгаанд өргөмжлөн уг хэргийг эрхлүүлж, Их шавьд албан ёсоор харьяалуулсан бололтой. Харин Илтгэл шастир тэргүүтэй сурвалжууд 4 үе хувилан төрсөн хэмээн бичих болсон нь Их шавьд захирагдсан цаг хугацаанаас тооцож анхны хутагтыг Лувсангэлэгээс эхлүүлжээ гэж үзэж болохоор байна.

Дарьгангад албан ёсоор тахигдсан хувилгаан Лувсангэлэг хэдэн онд хаана мэндэлснийг баримтуудад нэлээд зөрүүтэй тэмдэглэсэн байна. Тухайлбал:

Илтгэл шастир, Богдын шавийн долоон хутагтын уг эх-д ...*Тэнгэрийг тэтгэсний 2-р (1737) онд халхын газраа хувилгаан гарсан гэсэн бол доктор*

²³ *Дарьгангын түүхэнд холбогдох баримтууд* (Баримт бичгийн эмхэтгэл), эмх.Т.Билэгсайхан, Улаанбаатар: Соёмбо, 2020, 59.

²⁴ *Монгол улсын шастир* (дэд дэвтэр), Улаанбаатар: Соёмбо, 2006, 398.

²⁵ *Монголын сүм хийдийн түүхээс ...*(Баримт бичгийн эмхэтгэл), эмх Б.Эрдэнэбилэг, Улаанбаатар: ТЕГ-ын хэвлэх, 2014, 174.

²⁶ *Монголын сүм хийдийн түүхээс ...*(Баримт бичгийн эмхэтгэл), эмх Б.Эрдэнэбилэг, Улаанбаатар: ТЕГ-ын хэвлэх, 2014, 174.

Д.Дашбадрах XII жарны улаагчин могой жил буюу 1637 онд²⁷ Сэцэн хан аймгийн бэйс Содномдоржийн хошууны сум ард Балсангийн гэрт мэндэлсэн²⁸ ТЕГ-ийн баримтад 1775 онд ...*Сэргэлэн гүний хошууны Лувсандоржийнд төрсөн*²⁹ зэргээр зөрүүтэй бичигджээ. (Нягтлан үзүүштэй) Лувсангэлэнг найман настай байх ахуйд Лувсанжамбын хувилгаан болохыг ...*Егүээр ламаар мэргэлүүлэн тус хийд*³⁰-ийн ширээнд залсныг хойно II Богдод айлтган өмнө өгүүлснээр Их шавьд захируулж Дарьгангад тахигдсан ламаар өргөмжлөн баталжээ. Тэрээр 1776 онд ...*харьяа сүргийн олон лам нарыг авч хоёрдугаар зэрэг тангад үсгээр Ганжуур ном нэг хувь залаад, хувилгаан эзний түмэн өлзий итгэл болох тул үүрд шүтэн тогтоосугай хэмээн Зарлигаар Ганжуур ном нэг хувийг залсан*³¹ амой. Ганжуур номоо ...*нэгэн жилд нэг удаа гурван өдөр дараалан хурж байхаар мөнхөлжээ*.³²

Хувилгаан 1772, 1782 онуудад хоёр удаа Халуунаас зайлах ордноо очиж хишиг хүртэж явсан байна.

Лувсангэлэг хувилгаан 1789 онд жанч халсан³³-д ...*түүний шарилыг чандарлан хоёр чи хэмжээний гуулин шармал суваргад агуулан мөнхүү гэр дуганд залж, түүний хойтын буянд ...сар бүхийн 12-нд Дэлгэр ламирам, Түй*³⁴ зэрэг хурлыг мөнхөлжээ.

Хувилгаан Жигмэддорж XIII жарны цагаан нохой жил буюу 1790 онд Халхын Сэцэн хан аймгийн бэйл Дагвадаржаагийн гэрт мэндэлжээ.³⁵ Хөвгүүнийг Лувсангэлэнгийн хойд дүр мөн эсэхийг Бандид гэгээнээр мэргэлүүлж тодруулснаа Сайшаал ерөөлтийн 16 онд (1812) Журганд айлтган ...*Жигмэддорж хэмээх нэртэй хөвгүүнийг даруй лам Лувсангэлэгийн хувилгаан мөн*³⁶ хэмээн мэдүүлэн зөвшөөрөл авснаар Дарьганга нутагт залж, урьд үеийн хувилгааны айлтган залж авчирсан Ганжуур ном дуудан, Дарь овоог тайлгах зэрэг хэргийг даалгажээ.

Хувилгааныг тодруулсны дараа шавь нараас IV Богдод хүсэлт тавьж
Оюун их сайн үйлсийн охь цадиг хийгээд
Орны барилдлага аюул үгүй үйлсийн чуулган

²⁷ XII жарны улаагчин могой жил буюу 1637 он техник алдаа гарган бичжээ. Уг он 1737 болно.

²⁸ Дашбадрах Д. *Монголын хутагтууд, Монголын хутагтуудын намтрын ойллого (XVII-XX зуун)* Улаанбаатар: 2004, 171.

²⁹ *Монголын сүм хийдийн түүхээс* ... (Баримт бичгийн эмхэтгэл), эмх Б.Эрдэнэбилэг, Улаанбаатар: ТЕГ-ын хэвлэх, 2014, 174.

³⁰ *Монголын сүм хийдийн түүхээс* ... (Баримт бичгийн эмхэтгэл), эмх Б.Эрдэнэбилэг, Улаанбаатар: ТЕГ-ын хэвлэх, 2014, 174.

³¹ *Дарьгангын түүхэнд холбогдох баримтууд* (Баримт бичгийн эмхэтгэл), эмх.Т.Билэгсайхан, Улаанбаатар: Соёмбо, 2020, 59.

³² *Монголын сүм хийдийн түүхээс* ... (Баримт бичгийн эмхэтгэл), эмх Б.Эрдэнэбилэг, Улаанбаатар: ТЕГ-ын хэвлэх, 2014, 175.

³³ *Дарьгангын түүхэнд холбогдох баримтууд* (Баримт бичгийн эмхэтгэл), эмх.Т.Билэгсайхан, Улаанбаатар: Соёмбо, 2020, 59.

³⁴ *Монголын сүм хийдийн түүхээс* ... (Баримт бичгийн эмхэтгэл), эмх Б.Эрдэнэбилэг, Улаанбаатар: ТЕГ-ын хэвлэх, 2014, 175.

³⁵ Богдын шавийн долоон хутагтын уг эх, МҮНС, Монгол судлал, гар бичмэлийн сан хөмрөг, 36/96.

³⁶ Богдын шавийн долоон хутагтын уг эх, МҮНС, Монгол судлал, гар бичмэлийн сан хөмрөг, 36/96.

Очирын орны хоёр чуулганыг сайтар баттай дэлгэрүүлээд

*Богд тойноос лам танд соёрхол талбия*³⁷ гэх залбирлыг³⁸ зохиолгосон. Уг номын тайлбарт ...Энэ дөрвөн шад нь Дарьгангын Мэргэн хутагтын түнрэв солдэв. Ялгуусан бүгдийг айлдагчид айлтган зохиолгосон. Гүж Лувсанжигмэддоржийн шавь нар нь дурдсаны тухайд гэтэлгэгч дээдийн нэрийг баригч бээр бичсэн³⁹ хэмээсэн буй.

Жигмэддорж хувилгаан 1817,1826,1832,1838,1842,1844 онуудад 6 удаа Нийслэл хотод (Бээжин) Түнлэ ном хурах хуралд жасаалан суусанд удаа бүр нэжгээд интэй торго хадаг, эрдэнэсийн сан чулуун эрх, булга, хөөрөг, шаазан сав зэрэг зүйлийг шагнан олгожээ.⁴⁰ 1844 онд зарлигаар ногоон өнгөт хөшиг сүйх тэрэг хэрэглэх ямба шагнагдсан амой.

Эл үед хутагт 900 орчим шавь нарыг захирч⁴¹ байжээ. 1853 онд жанч халсанд ...чандарлан хоёр чи хэмжээний гуулин шармал суваргад хийж залж, хойдын буянд зориулан сар бүрийн найманд Найдан чоги хурж байхаар мөнхөлжээ.

Дондовбал хувилгаан IV зууны хөхөгчин туулай жил буюу 1855 онд⁴² Сэргэлэн гүний хошууны ард Ядамжавын⁴³ гэрт мэндэлжээ. 1857 онд ...Халхын газраа хувилгаан гарч⁴⁴ 1859 онд ...Журганаас шавга татаж айлтгаад, уул шавь нарт нийлүүлэн суулгасан аж.⁴⁵ 1883 онд ...Түмэн өлзий ном уншихын тулд Дарьгангын нутагт Орлойн гурван зээрд хэмээх газарт 55 тасалгаат гэр сүм байгуулж, Ганжуурын зэрэг олон зүйлийн ном бурхан залж тахиад гурван зуугаад лам нарыг суулгаж мөнхүү сүмд нэр шагнуулахыг гүйн, зарлигаар Өглөгийг бадруулсан сүм⁴⁶ (འཇམ་དཔལ་ལྷན་པོ་ Жинбадаржаалин) хэмээн нэр шагнан олгуулсан байдаг. Энэ тухай Дээрхийн уг эхэд ...лам Жигмэддоржын хувилгаан Дондонбал нар өөрийн бие ба урьд үе дор цөм тавин тасалгаанаас дээш үйлдэж байгуулсан сүмүүдэд тус тус нэр шагнуулахыг гүйн өргөснийг цөм журганаас уламжлан айлтгаад ...нэр шагнан олгосныг данс дор тэмдэглэжээ⁴⁷ хэмээсэн байна.

³⁷ IV Богдын сүмбүм дэх залбирлын төвөд эхийг Зүүн хүрээ Дашчойлин хийд Бурхны шашин соёл судлалын хүрээлэнгийн Ph.D Г.Мягмарсүрэнгээс авав.

³⁸ Залбирал буюу (түнрэв солдэв)

³⁹ IV Богдын сүмбүм

⁴⁰ Дарьгангын түүхэнд холбогдох баримтууд (Баримт бичгийн эмхэтгэл), эмх.Т.Билэгсайхан, Улаанбаатар: Соёмбо, 2020, 59.

⁴¹ Дарьгангын түүхэнд холбогдох баримтууд (Баримт бичгийн эмхэтгэл), эмх.Т.Билэгсайхан, Улаанбаатар: Соёмбо, 2020, 59.

⁴² Дашбадрах Д. Монголын хутагтууд, Монголын хутагтуудын намтрын ойллого (XVII-XX зуун), Улаанбаатар: 2004, 171.

⁴³ Монголын сүм хийдийн түүхээс ...(Баримт бичгийн эмхэтгэл), эмх Б.Эрдэнэбилэг, Улаанбаатар: ТЕГ-ын хэвлэх, 2014, 175.

⁴⁴ Монгол Улсын шастир (дэд дэвтэр), Улаанбаатар: Соёмбо, 2006, 399.

⁴⁵ Монгол Улсын шастир (дэд дэвтэр), Улаанбаатар: Соёмбо, 2006, 399.

⁴⁶ Монгол Улсын шастир (дэд дэвтэр), Улаанбаатар: Соёмбо, 2006, 399.

⁴⁷ Дээрхийн уг эх, VII дэвтэр, Улаанбаатар: Соёмбо, 2019, 25.

Энэ цагаас хутагтын хүрээ суурьшсан бөгөөд тэрээр Санжидмолон, Янлагдүмба⁴⁸ гэх хурлуудыг байгуулж тус тусын жасуудыг байгуулсан байна. 1889 онд жанч халсанд урьдах дүрийн адил чандарлан залжээ.

Ринчинбадам XV жарны шарагчин үхэр жил (1889) Сэцэн хан аймгийн Боржгин Сэцэн вангийн хошууны⁴⁹ ард Намсрайн⁵⁰ гэрт мэндэлжээ. Хутагтыг сурвалжуудад Ринчинбадам, Лодойринчин гэж хоёр янзаар бичдэг. Төрийн албан ёсны баримт бичгүүдэд Ринчинбадам нэрээр бичигдэх бол шашны номд Лодойринчин гэх сахилын нэрээр тэмдэглэгджээ. Мэргэн хутагтын солдэв 16 шад номд байдгаас хоёр дахь шад шүлэг номд


Сайн оюутад алдаршсан төгөлдөр баригч чин зоригт

Их эрдэнийн эш дамжлагын язгуурыг цогцлох ялсны тэмдгийн үзүүрт

Тус амгалан, хэрэг бүхнийг байгуулахыг соёрхон зохиогч

Лодойринчин таны өлмийд залбирал тавья⁵¹ хэмээн хутагтын алдрыг оруулан шүлэглэжээ. Уг мөргөлийг хутагтын хүрээний лам нар уншдаг байсан, өдгөө ч дахин сэргэсэн Орлойн мэргэн хутагтын хүрээний Цогчэн хуралд өдөр бүр уншигдаж байна. Энэ залбирлыг хэн хэзээ хутагтдаа зориулан бичүүлж, хуралд уншигдаж эхэлсэн нь тодорхойгүй, тэр хэсэг нь үрэгдэж алга болсон бололтой.

Зураг 1 Мэргэн хутагт Лодойринчингийн солдэв



Зургийн эх сурвалж: Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Дэчинчойнхорлин хийдийн тэргүүн лам Д.Жигмэджамцаас авав.

Хутагтыг 1892 онд Журганаас хууль ёсоор шаваг татаж айлтгаад, уул шавьд нийлүүлэн суулгасан байдаг. Мөн Их шавийн харьяа хутагтууд шашны эрдэмд Их хүрээнд ирж боловсордог. Ринчинбадам хутагтыг 1902 онд ...*манай харьяа шавийн Орной мэргэн хутагтын хувилгаан Ринчинбадам 10 илүү насанд хурч хүрээнд сууж ном сургууль үйлдвээс зохих болсон атал түүний харьяат шавь эдүгээ хүртэл хүрээнд суулгах үгүй нь зохих үгүй тул хамба шанзудбын газраас зохигчдод тушаан тэр хувилгааныг энэ жил хүрээнээ суулгагтун*⁵² гэсний дагуу Их хүрээнд

⁴⁸ Монголын сүм хийдийн түүхээс ... (Баримт бичгийн эмхэтгэл), эмх. Б.Эрдэнэбилэг, Улаанбаатар: ТЕГ-ын хэвлэх, 2014, 175.

⁴⁹ Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын Гурван цагаан булаг хэмээх газар мэндэлжээ.

⁵⁰ Монголын сүм хийдийн түүхээс ... (Баримт бичгийн эмхэтгэл), эмх. Б.Эрдэнэбилэг, Улаанбаатар: ТЕГ-ын хэвлэх, 2014, 176.

⁵¹ Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Дэчинчойнхорлин хийдийн тэргүүн лам Д.Жигмэджамцаас төвөд судрын зураг авав.

⁵² МУУТА, М-85 Д-2 ХН-950 2 нуг.

ирж суралцах ёстой байсан ч мөн оны 9 сард Зарлигаар зарсан Хүрээнд суух хэрэг шийтгэх сайдуудаас ...эдүгээ Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамнаас дотоод гадаад засгийн хутагт хувилгаан лам нарыг заран жасаа зохиож жил бүрийн жасаа дараалан Нийслэл хотод ирж бараалхан түнли ном унших хутагт ...харьяа шавийн хувилгаан Ринчинбадам ...энэ жилийн 11 сарын 20-ны урьд хотод хүргүүлэхийг тушаасан ёсоор⁵³ жасаанд явсан байна. Хутагт 1899 онд ..Дундад улсын дотор мөнгө агсан авч үнэтээр Жапан улс дор өгч, тэмдэгт бичиг олгох ажилд Жибзундамба хутагтын шавиас найман түмэн лан мөнгө туслан барихад ...лам Дондонбалын хувилгаан Ринчинбадмаа 500 лан мөнгө улсын санд мөнгө туслан⁵⁴ хандивласанд ...торго дөрвөн энтэй⁵⁵ шагнасан. 1911 оны 12 сарын 29-нд Монголчууд төрийн тусгаар тогтнолоо дахин сэргээн мандуулж Богд Жибзундамба хутагтыг хаан өргөмжилж хишиг хүртээн зарлиг буулгахад ...Мэргэн хутагтад үүрд ногоон тэрэг, хүрэн жолоо⁵⁶-гоор шагнуулсан.

Тэрээр хүрээндээ 1893 онд лам Шаравжамцын өргөсөн эсгий гэрт ...өдөр бүрийн Цогчэн мөнхөлж⁵⁷ хуруулсан. 1894 онд ..Давуу дуган нэгийг шинээр барьж, түүнд Дашиям равнай өргөн, урьдын бурхан шүтээн Ганжуур зэргийг дотор нь залж, урьд хурал Цэдэрлхам, хуучин Хангал, зул ерөөл, Маанийн бүтээл, Гүнрэг зэрэг хурлуудыг хурах ...жасын хөрөнгөнөөс 12 ханатай гэр дуган барьж дээр дурдсан бүхий л хурлыг өвлийг цагт хурж байхаар болгожээ.⁵⁸ 1902 онд Маналын хурлын жас байгуулсан, 1908 онд Их хүрээнээс ..Данжуур судар, мөн 3 чи хэмжээний Майдар шармал нэгийг авчран, Цогчэн сүмд залж, жилд нэг удаа Данжуурыг гурван өдөр, Майдарыг жилд нэг удаа байхаар мөнхлөн залжээ.⁵⁹ 1918 онд ...модон дуган нэгийг барьж Чойр дацан байгуулахаар Бизъяагийн аймгийн лам гавж Навааныг залж ирүүлэн равнай өргөж, Чойрын хурлыг дэглүүлэн,⁶⁰ Ванчин Содномдагвын игчааг⁶¹ хэлэлцүүлэн гучин нэгэн ламтайгаар байгуулсныг Зава Дамдин Алтан дэвтэр зохиолдоо ...Орлойнн мэргэн хутагтын хийдэд Лолин егчаны чойр тэргүүтэн буй бөгөөд хувраг нэлээд хэдэн зуу

⁵³ МУУТА, М-85 Д-2 ХН-950 21 нуг.

⁵⁴ Дээрхийн уг эх, VII дэвтэр, Улаанбаатар: Соёмбо, 2019, 30.

⁵⁵ Дээрхийн уг эх, VII дэвтэр, Улаанбаатар: Соёмбо, 2019, 50.

⁵⁶ МУУТА, А-6 Д-1 ХН-513.

⁵⁷ Монголын сүм хийдийн түүхээс ...(Баримт бичгийн эмхэтгэл), эмх. Б.Эрдэнэбилэг, Улаанбаатар: ТЕГ-ын хэвлэх, 2014, 176.

⁵⁸ Монголын сүм хийдийн түүхээс ...(Баримт бичгийн эмхэтгэл), эмх. Б.Эрдэнэбилэг, Улаанбаатар: ТЕГ-ын хэвлэх, 2014, 176.

⁵⁹ Монголын сүм хийдийн түүхээс ...(Баримт бичгийн эмхэтгэл), эмх. Б.Эрдэнэбилэг, Улаанбаатар: ТЕГ-ын хэвлэх, 2014, 176.

⁶⁰ Монголын сүм хийдийн түүхээс ...(Баримт бичгийн эмхэтгэл), эмх. Б.Эрдэнэбилэг, Улаанбаатар: ТЕГ-ын хэвлэх, 2014, 176.

⁶¹ Төвөдийн Сэра, Гандан, Барайван дацангууд Сэржавзанбын бичсэн “Сэрийн игчаа”, Банчин Сономдагвын “Банчин игчаа”, Гүнчинжамьяншадавын гаргасан “Гүнчин игчаа”-г баримтлан гүн ухааны сургалтаа явуулдаг байсан нь Монгол оронд дэлгэрсэн. Орлойнн мэргэн хутагтын хүрээнд Брайвүн хийдийн Лосаллин (төв. blo-gsal- gling) дацангийн Банчин игчаа (сургалт)-тай байжээ. Зава Дамдин гавж Лосаллин дацанг Лолин хэмээн тэмдэглэсэн байна.

байна⁶² хэмээн өгүүлжээ. Тус дацандаа ...1919 онд явган хүний адил хэмжээтэй Явсрайсүм⁶³ хэмээх бурхныг үйлдэж, Их хүрээнээс авчран, равнай өргөж, Чойр дацанд шүтсэн.⁶⁴

1923 онд ...Зуугийн туйнуу бага сүм нэг, Гүнрэгийн бага туйнуу сүм нэг, хувилгааны суух модон байшин нэг, их жасын туйнуу хоёр-⁶⁵ыг барих зэргээр өөрийн хүрээндээ дуган сүм бариулах, бурхан шүтээн залах, хурал ном шинээр үүсгэх зэргээр хийд орноо өргөжүүлэн хөгжүүлсэн байна. Тус хүрээ ...дунд үедээ 226 лам хурдаг, жасын мал адуу 326, үхэр 78, хонь 1779, ямаа 78, тэмээ 103 -тай⁶⁶ байсан хэмээжээ.

1920 оны дунд үеэс төрөөс хутагтын шавийн захиргааг устгах, хутагт хувилгаадыг дахин тодруулах, шүтэх явдлыг хориглох зэрэг шат дараалсан олон бодлогыг хэрэгжүүлснээр хутагт хувилгаад хийд орноо тэргүүлэн ажиллахыг зогсоосон. 1928 онд Дарьганга дахь сүм хийдүүдийн үйл ажиллагааг нэгтгэн Шашны захиргааны байгуулахдаа Мэргэн хутагтын хүрээг түшиглэн ойролцоо нутагтай 8 сүм хурлыг нэгтгэн,⁶⁷ Жинбадаржаалин шашны захиргааны газрыг байгуулж хамба болон тэргүүн ламыг захиргааны анхдугаар хурлаар сонгосноор Мэргэн хутагт өөрийн хүрээний хэргийг тэргүүлэн ажиллахаа больсон байдаг. 1929 онд хийгдсэн Хан Хэнтий уулын аймгийн хутагт хувилгаадын бүртгэлд ...Орной мэргэн хутагт Ринчинбадам 42 настай, ард, эцэг Цэрэнням, дүү Санжаа, Сүрэн. Богдыг байх үед 30 гаруй бодтой байсан одоо 100 гаруй бодтой. 17,18 (1927,1928) онуудад улсын татварт 129, 125 төгрөг 55, 66 мөнгө хураасан. Хөрөнгө малаа ядуу ардад өгч хадгалуулдаг. Сум Уулбаянмөнх сумын 9 хорин Лагт хэмээх газар байгуулсан Өглөг бадруулагч хийд дээр сууж буй. Урьд шавь нар хэмээж явсан ард 50 шахам ам 100 гаруй болно. 5 удаа хувилгаан гарсан. Эзэрхэг үед гавьяа байгуулсангүй⁶⁸ хэмээн мэдүүлж байсан байна.

Ринчинбадам хутагт ...1933 онд хэргийн учир баригдан яваад төв эмнэлэгт эмчлүүлж байгаад⁶⁹ жанч халсан байна.

Дээрх баримтуудыг харьцуулан үзэхэд Орлойн мэргэн хутагтын таван дүр, Монголд оронд тодорч шашин номын үйлийг Дарьганга нутагт үүсгэн дэлгэрүүлж явжээ. Хоёрдугаар дүр Лувсангэлэг Халхын шашны эзэн

⁶² Зава Дамдин Лувсандаян. Их Монгол орон бурханы шашин дэлгэрсэн түүх Алтан дэвтэр, төвөд хэлнээс орч. С. Гантөмөр Улаанбаатар: Адмон, 2018, 263.

⁶³ Явсрайсүм буюу Богд Зонхов Хайдавжий, Жалцавжий хоёр шавийн хамт бүтээлгэжээ.

⁶⁴ Монголын сүм хийдийн түүхээс ...(Баримт бичгийн эмхэтгэл), эмх. Б.Эрдэнэбилэг, Улаанбаатар: ТЕГ-ын хэвлэх, 2014, 176.

⁶⁵ Монголын сүм хийдийн түүхээс ...(Баримт бичгийн эмхэтгэл), эмх. Б.Эрдэнэбилэг, Улаанбаатар: ТЕГ-ын хэвлэх, 2014, 176.

⁶⁶ Монголын сүм хийдийн түүхээс ...(Баримт бичгийн эмхэтгэл), эмх. Б.Эрдэнэбилэг, Улаанбаатар: ТЕГ-ын хэвлэх, 2014, 176.

⁶⁷ Жинбадаржаалин шашны захиргааны газарт Өглөгийг бадруулагч сүм, Рашаант сүм, Бударганын хурал, Молцог сүм, Сөдөт сүм, Талын модон сүм, Сайн худгийн хурал, Эрдэнэ -өлзийт сүм Хайсын хурал, Бүгэрсэлэн сүм, Маанийн хурал гэх хурал номын газрууд багтаж байжээ.

⁶⁸ МУУТА, X-1 Д-6 ХН-220.

⁶⁹ Монголын сүм хийдийн түүхээс ...(Баримт бичгийн эмхэтгэл), эмх. Б.Эрдэнэбилэг, Улаанбаатар: ТЕГ-ын хэвлэх, 2014, 176.

Жибзундамба хутагтын шавьд захирагдах болсон төдийгүй Дарьганга нутагт төрөл үе хувиран төрсөн Лувсан, Чагдар, Шагдарсүрэн, Лувсандоной зэрэг 10 хувилгааны⁷⁰ байсны хамгийн нөлөө бүхий хутагт нь байв. Орлойн хутагтууд орон хийдүүдээ байгуулж суурьшсан газар бүртээ хийд орон үлдээж ном хурлыг дэлгэрүүлж явсан аж.

2. Хутагтын хүрээний байршил ба сүм хийд лам нар

Мэргэн хутагтууд хүрээнийхээ дацан сургууль, хурал номыг үүсгэж өргөтгөн хөгжүүлснээр Дарьганга төдийгүй, Халх даяар Мэргэн хутагтын хүрээ, Ламтын хүрээ хэмээн алдаршсан, шашин номын төв болон оршиж байжээ.

Хутагтын хүрээ нэг газар суурьшилгүй олон удаа нүүдэлжээ. Иймээс энд хүрээ нэг газраа суурьшилгүй нүүдэллэхийн шалтгаан юу байв. Суурьшиж байсан газрууд одоогийн Сүхбаатар аймгийн аль сумны нутагт буйг тодруулан үзэхийг оролдлоо.

Хутагтуудын байгуулсан хийд орны үлдэц тууриуд өдгөө байдгийг нутгийн ардууд хуучлан ярилцахын сацуу тэр газрууд дахь уул овоог тахиж шүтсээр ирсэн ажээ. Сурвалжид нэр нь дурдагдаж буй газруудын тухай Баяндэлгэр сумын харьяат Д.Амараа, Монголын сүм хийдийн түүхэн товчоо төсөлд оролцсон нутгийн хөгшчүүдийн аман яриаг энд орууллаа.

Өгөөмөрийн хийд: Хутагтын хүрээ анх энэ газар эсгий гэрт 7 ламтайгаар хурал номын үйлийг эхлүүлж 12 жил суурьшсан ч усгүй гэх шалтгаанаар нүүсэн, хожим Жигмэддорж гэгээнтэн дахин ирж хийд орноо байгуулсан нь Дарьгангын Өгөөмөрийн хийд болно. ...Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Төв багийн нутаг Өгөөмөр овооны урд өвөрт хийдийн туурь нь байдаг.⁷¹ Гэгээнтэн “*Өгөөмөр ууланд орших суурины эзний соёрхол тахил дурилаас хагацсан номын чанарт эх орших болой*” гэх тахилгын судрыг VII Банчэн-Эрдэнэд хүсэлт тавин бичүүлжээ. Судрын төгсгөлд *..Дарьганга хошууны Эрдэнэ мэргэн хутагтын хувилгаан Жигмэддорж хүссэний хариуд шагжсийн гэлэн Лувсанбалданданбинямчоглайнамжалбалсанбо бээр найруулав*⁷² хэмээн бичсэн байдаг. Овоог хэрхэн тахидаг байсныг нутгийн ард Б. Отгонбаяр *...Ламтан жил бүр хаврын сүүл, зуны эхэн сард Өгөөмөрийн овоог тахидаг байв. Овоо тахилгын үеэр нутаг хошуугаараа цуглаж бөх барилдан, морь уралдаж наадам хийдэг байжээ. Хутагт хоёр хүрэн халзан морь азаргатай сунтгаар явж овоогоо тахихад нь есөн цагаан морьтон овоог эргэдэг байсан*⁷³ гэж дурсан ярьж байжээ. Өдгөө ч нутгийн айлуудад тахилгын судар хадгалагдах ба овоогоо тахиж шүтсээр байна.

⁷⁰ МУУТА, Х-11 Д-1 ХН-113.

⁷¹ Д.Амараатай 2024 оны 10 сар хийсэн ярилцлага.

⁷² Тахилгын судрыг Зүүн хүрээ Дашчойлин хийдийн лам М.Нандинбаатараас авсан.

⁷³ Түмэннаст, Я. *Сэтгэлд зүмбэрлэх наран диваажин миний Баяндэлгэр*, Улаанбаатар: 2015, 297.

Зураг 2. Өгөөмөрийн овоо



Эх сурвалж: Нутгийн ард А. Амараагаас авсан зураг

Дунд худгийн хийд: Сурвалжид, Лувсангэлэг хутагтыг жанч халсны хойно ...Отгийн дарга Жадамбаас олонд нутаг үл тохирох шалтгааныг айлтгаад тус хийдийг нүүлгэн Дунд худаг⁷⁴ гэх газарт суурьшжээ.

Дунд худгийн хийд нь ...Баяндэлгэр сумын Төв багийн нутаг Өгөөмөрийн уулаас зүүн хойш 10 гаран км газар Эхэн худаг, Дунд худаг, Адгийн худаг гэж газар бий. Дунд худаг амтай (амны ус). Дунд худгийн баруун дээр гэрийн буурь шиг дугараг чулуун хүрээ, хөх тоосгоны булан зэрэг байх бөгөөд сүмийн туурь байж болохоор газар одоо их элэгдэж баларсан байдаг. Тэгэхээр тэр газар бол Дунд худгийн сүмийн туурь мөн байж болох талтай. Манай нутгийн өндөр настан Чимэддорж гуай ...Өргөн цагаан дэрсний хойд талд бараг говьд дотор багахан устай улаан шандыг лам нарын ус гэж ярьдаг байсан. Говь дотор байгаа мөртөө шүүгүй аманд уудаг хамгийн цэвэр устай, модон хүрээтэй шанд байсан хэмээн дурсан ярьж байсан.⁷⁵ Хутагтууд Өгөөмөрийн овоо, Дарь овоог тайх хэргийн тухайд аялан явахдаа “Улаан довын шанд” гэх энэ газраас ус ундаагаа базаадаг байснаас ламын ус гэж нэрлэх болжээ.

Их булгийн хийд: Лувсангэлэг хутагт 1784 онд Бүгдийн даргад айлтган ...зарлигаар Дарьгангын адууны нутаг Их булаг хэмээгч газарт дуган⁷⁶ байгуулжээ. Өдгөө Сүхбаатар аймгийн Онон сумын нутагт туурь нь буй. Их булгийн хийд байгуулагдсаныг сурвалжууд зөрүүтэй тэмдэглэсэн байна. ...Бүрэн засагчийн 2-р онд (1862) ..Да лам Лодон 1500 лан гаргаж, дуган сүм бариулав. 100 ламтай Маанийн бүтээлийн хурал үүсгэв. Дараа Хайлан, Гүнрэг, Чогчин, Манба, Чоймполор хурах болов.⁷⁷ Анхны сүмд Журганаас Жамъяалин нэр

⁷⁴ Монголын сүм хийдийн түүхээс ...(Баримт бичгийн эмхэтгэл), эмх. Б.Эрдэнэбилэг, Улаанбаатар: ТЕГ-ын хэвлэх, 2014, 175.

⁷⁵ Д.Амараатай 2024 оны 10 сар хийсэн ярилцлага.

⁷⁶ Дарьгангын түүхэнд холбогдох баримтууд (Баримт бичгийн эмхэтгэл), эмх.Т.Билэгсайхан, Улаанбаатар: Соёмбо, 2020, 59.

⁷⁷ Монголын хүрээ хийдийн түүх (эмхтгэл) Эмх. Ч.Банзрагч, Б.Сайнхүү, Улаанбаатар: Соёмбо, 2004, 210.

олгосон⁷⁸ хэмээжээ. Магадгүй Мэргэн хутагтын байгуулсан дуганыг Да лам Лодон өргөжүүлэн дуган сүм нэмэн барьж байнгын үйл ажиллагаатай хийд орон болгосон байж болох юм.

Эрдэнэ толгойн хийд: Жигмэддорж хутагт 1853 онд жанч халсанд ...лам үл тогтох учраас шалтгаалан нүүж, Эрдэнэ толгой хэмээх газар буулгажээ.⁷⁹ Одоогийн Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Хонгор багийн нутагт “Эрдэнэтолгой” хэмээн намхан овооны урд энгэрт хоёрын зэрэг дөрвөлжин чулуун суурь бүхий ором туурийг нутгийнхан Орлойн хутагтай холбон ярьдаг.⁸⁰ Сумын төвөөс зүүн зүгт 25 км-т Эрдэнэ толгойн өвөрт, Хавцалын шил хэмээх газар орших хурлын газар нь зүүн талд нь Бага оорцог, баруун талдаа Их мандал гэдэг уултай⁸¹ хэмээн дурсан ярьсан.

Зураг 3



Эх сурвалж: Нутгийн ард А. Амараагаас авсан зураг

Өглөгийн бадруулагч хийд: Дондовбал хутагт 1884 онд Түмэн өлзий ном уншихын тулд Дарьгангын нутагт Орлойн гурван зээрд хэмээх газарт 55 тасалгаат гэр сүм байгуулан зарлигаар Өглөгийг бадруулагч нэр шагнуулснаар энэ газар хүрээ суурьшжээ. Хүрээ хаана байсныг нутгийн ардууд ийн өгүүлэв.

Д.Амараа Дарьгангын сүрэгчин таван гарын баруун хойд зах газар Баруун гар тэмээчний нутаг. Одоогийн Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Баян багийн нутагт буй Баруун зээрд, Дунд зээрд, Зүүн зээрд нэртэй баруунаас зүүн тийш үргэлжлэх цувраа уулсыг Орлойн гурван зээрд хэмээдэг.⁸²

Базар (Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Гандандамбадаржаалин хийдийн хамба) Мэргэн хутагтын хийд буюу Ламтны хийд урдуураа Санданжун

⁷⁸ Монголын сүм хийдийн түүхэн товчоо, Улаанбаатар: Адмон, 2009, 599.

⁷⁹ Монголын сүм хийдийн түүхээс ...(Баримт бичгийн эмхэтгэл), эмх. Б.Эрдэнэбилэг, Улаанбаатар: ТЕГ-ын хэвлэх, 2014, 175.

⁸⁰ Д.Амараатай 2024 оны 10 сар хийсэн ярилцлага.

⁸¹ Монголын сүм хийдийн түүхэн товчоо төсөл, <https://mongoliantemples.org/en/component/domm/530?view=oldtemplemn>

⁸² Д.Амараатай 2024 оны 10 сар хийсэн ярилцлага.

овоо, баруун талаараа Их лагтын өндөр хэмээх худаг, хойгуураа Хүүхдийн овоо, Түгжамбын шанд, Алтан тэвш, зүүн талаараа Бага Лагтын худгаар хүрээлэн оршиж байжээ.⁸³

Ч. Донров ...Баяндэлгэрээс хойш Түвшинширээгээс урагшаа Ламтны хийд гэж бий, Лагт гэдэг газар байрлаж байгаа. Тэр чинь бас Түвшинширээ, Баяндэлгэрийн харьяа хийдийн нэг шүү. Орлойн гурван зээрд Онгон таван булгаас баруун урагш Баруун, Зүүн, Дунд гурван Орлойн гэдэг чинь Баяндэлгэр сумын арын гурван зэрэгцсэн уул шүү дээ⁸⁴ хэмээн уг хийд хаана байсныг өгүүлсэн.

1789 онд тогтоосон Дарьгангын нутгийн хилийн цэсэд ...Баруун этгээдэд Лагду хөх баруут, Таван толгой, Дунд зээрд хүртэл Дарьгангын баруун хойд өнцөг, засаг Намжилын хошуу баруун өмнөд өнцөг, Түшээт хан аймгийн Доржжавын хошууны нутгийн зүүн зах нийлнэ.⁸⁵ 1791 онд Шаварт Өөшөөс баруун этгээд засаг Цэрэннамжилын хошуу, Дарьгангын сүргийн зах нийлэх Лагт хөх баруут, Таван толгой дайран хуучин нэр бүхий гурван зээрдийн Дунд зээрдэд⁸⁶ зэргээр хил тогтоон овоо тэмдэг байгуулсныг архивын баримтуудад тэмдэглэжээ.

Зураг 4



А.



Б.

Эх сурвалж: Нутгийн ард А. Амараагаас авсан зураг

Дээрх дурсамж яриа, сүм хийдийн тууриуд, архивын баримтын мэдээнээс харахад Мэргэн хутагуудын хийд Дарьгангын таван гарын сүрэгчний баруун гар тэмээчин, хойд талаараа Сэцэн хан аймгийн Эрх засгийн хошуу, баруун талаараа Түшээт хан аймгийн Мэргэн вангийн хошуудтай зах нийлэн оршиж

⁸³ Монголын сүм хийдийн түүхэн товчоо төсөл, <https://www.mongoliantemples.org/mn/monk-mn/568?view=oldtemplemn>

⁸⁴ Монголын сүм хийдийн түүхэн товчоо төсөл, <https://www.mongoliantemples.org/oralhistorypdfs/L126.pdf>

⁸⁵ Дарьгангын түүхэнд холбогдох баримтууд (Баримт бичгийн эмхэтгэл), Дарьгангын түүхэнд холбогдох баримтууд (Баримт бичгийн эмхэтгэл), эмх.Т.Билэгсайхан, Улаанбаатар: Соёмбо, 2020, 42.

⁸⁶ Дарьгангын түүхэнд холбогдох баримтууд (Баримт бичгийн эмхэтгэл), эмх.Т.Билэгсайхан, Улаанбаатар: Соёмбо, 2020, 44.

байсан байна.⁸⁷ Хутагтууд хийд орноо Баруун гарын тэмээчний нутаг одоогийн Баяндэлгэр сумын нутагт байгуулан шашин номын үйлээ явуулж, суурьшиж байсан газрууддаа хурал ном бүхий сүм дуган үлдээдэг байжээ. Тухайлбал, ...Өгөөмөрийн хийд нэг дацан, сүм дуган тав, жасын байшин тав, хашаа гурав, лам нарын 22 байшин, 23 хашаа⁸⁸ гэснээс харж болно. Ийнхүү олон удаа нүүхийн шалтгааныг сурвалжуудад усгүй болсон хутагт жанч халсан хэмээн дурджээ. Нүүдлийн гол шалтгаан нь говь нутагт ундны ус ховор байдагтай холбон үзэж болох юм. Хутагтуудын шашин номын үйл өргөжин тэлэхийн зэрэгцээ хувраг шавь нар олон болж нэг газар удаан суурьшин суух боломжгүй болж байсан болов уу? Хожим хутагтын хүрээ эргэн тойрон Бага Лагт, Лагт, Их Лагтын гэх худаг ус элбэгтэй газрыг сонгон суурьшсанаар өргөжин хөгжжээ.

Мэргэн хутагтын хүрээ хэчнээн ламтай байсныг 1918 онд 283,⁸⁹ 1921 онд 273⁹⁰ хуврагтай. ...*Хувилгаан блам Лувсангэлэгийн байгуулсан Өглөгийг бадруулагч буюу Жамбадаржаалин сүм 300 ламтай*⁹¹ 1929 онд Жамбадаржаалин хийд 500 ламтай⁹² гэх тоо баримтуудаас харж болно.

1920-иод оны дунд үеэс төрөөс шашныг хязгаарлах, хаах бодлогыг шат дараатай явуулсан. ТЕГ-ийн тусгай архиваас “Сүхбаатар аймгийн зарим сүм хийд, лам нарын баримтууд” гэх ном хэвлэгдэн гарсан. Уг номд 1932-оос 1937 онд бүртгэсэн бололтой, Хэнтий аймгийн Уулбаянмөнх⁹³ сумын лам нарын бүртгэл гэх баримтад хэвлэгджээ. Энд, Хутагтын хийдийн лам нар, Орлойн мэргэн хутагтын хүрээний лам нарын бүртгэл гэх баримтууд багтжээ. Хутагтын хийдэд 91 ламыг бүртгэгдсэн ба бүртгэгдсэн лам нарын дотор

...*Донойн Эринчинбадам, нас 43, үндсэн захиргаа Хэнтий аймаг Уулбаянмөнх сум, 8-р хороо, Мэргэн хэмээх хутагт феодал, Намсрайн Санжаа нас 40, Хэнтий аймаг Уулбаянмөнх сум, 8-р хороо, хутагтын хийд, Феодалын дүү*⁹⁴ хэмээн

⁸⁷ Одоогийн Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын хойд хэсэг Түвшинширээ сумын зүүн урд, Уулбаян сумын баруун урд хэсгийн залгаа нутаг.

⁸⁸ Монголын сүм хийдийн түүхэн товчоо, Улаанбаатар: Адмон, 2009, 586.

⁸⁹ МУУТА, А -74 Д-1 ХН-508.

⁹⁰ МУУТА, А-74 Д-1 ХН-662.

⁹¹ Монголын хүрээ хийдийн түүх (эмхтгэл) Эмх. Ч.Банзрагч, Б.Сайнхүү, Улаанбаатар: Соёмбо, 2004, 22.

⁹² Дарьгангын түүхэнд холбогдох баримтууд (Баримт бичгийн эмхэтгэл), эмх.Т.Билэгсайхан, Улаанбаатар: Соёмбо, 2020, 449.

⁹³ Ардын Засаг тогтсоны дараа Дарьганга Дотоод Яамны харьяанд байгаад засаг захиргааны шинэ хуваариар 1925 онд Хан Хэнтий уулын аймгийн Дарьганга хошуу болж сумын зохион байгуулалтад шилжүүлсэн. 1931 оны засаг захиргааны шинэчлэлээр Дарьганга хошууг Дорнод аймагт Асгат, Дарьганга, Молцог, Онгон, Халзан, Хонгор, Баяндэлгэр сумтайгаар зохион байгуулагджээ. Гэсэн ч Уулбаян, Түвшинширээ сумдын хил залгаа Баяндэлгэр сумын зарим нутаг Хэнтий аймгийн Уулбаянмөнх сумын нутагт харьяалагдсаныг Мэргэн хутагтын хүрээний 1930-аад оны баримтуудад Хэнтий аймгийн Уулбаянмөнх сумын Өглөгийг Бадруулагч хийд, Мэргэн хутагтын хүрээний лам нарын бүртгэл гэх баримтуудаас харж болно. Харин 1942 онд Жавхлант Шарга (Сүхбаатар) аймгийг шинээр байгуулахад уг хийд орон бүхий газрыг Баяндэлгэр сумын нутагт харьяалуулсан байна.

⁹⁴ Сүхбаатар аймгийн зарим сүм хийд, лам нарын баримтууд (1933-1937), Эмхэтгэсэн Д.Буджав, Улаанбаатар: ТЕГ-ын хэвлэх, 2020, 178.

тэмдэглэсэн байгаа нь Орлойн мэргэн хутагтын хүрээний лам нар болно. Хутагт бүртгэлд орсныг үзвэл 1932-1933 онд хийгдсэн баримт болно. Харин Орлойн мэргэн хутагтын хүрээний лам гэх 25 ламыг бүртгэл нь магадгүй хожим 1937 оны үед бүртгэсэн баримт болов уу? Эх баримтыг нягтлан үзүүштэй.

Ямартай ч хүрээ 1918 онд 283 хуврагтай байсан бол 1932 онд 91 ламтай болсон байна. Орлойн мэргэн хутагтын хүрээ нь төрөөс сүм хийдийг хаах шийдвэрийн дагуу Дотоод Явдлын Яамны Хэнтий аймаг дахь эзэнгүй болсон хийд жасын бүртгэлд ...*Мэргэн хутагтын хийд урьд шавь отгийн хийд байсан. Хийдэд суух лам үгүй, хурал ном хурж чадахгүй учир тараая. Хийдэд дацан байшин 1, дуган сүм 4, жасын байшин хийд 1, лам нарын хувийн байшин 41, энэ хийдийг тарах үед 3 лам, үүнээс хөдөөлөн орон гэртээ харьсан лам 3⁹⁵* хэмээнээр 1938 онд бүрэн хаагдсан байдаг.

Дээрх баримтууд нутгийн ардуудын ярианаас үзвэл Мэргэн хутагтын хүрээ хийд нь Дарьгангын баруун гарын тэмээчний нутаг одоогийн Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын нутагт байжээ. Хүрээ олон шалтгаанаар ойр зайд нүүдэлж байсан ч суурьшсан газар бүртээ сүм хийдүүдийг үлдээж явжээ.

3. Мэргэн хутагтын хүрээний хурал номын үйл хэрэг

Хутагтын хүрээний жаяг, хурал номын горим бидний үед бүрэн бүтнээрээ хадгалагдан үлдээгүй бололтой. Иймээс тус хүрээнд хурал ном ямар байсныг нутгийн ардуудын аман яриа, дахин сэргэсэн хийдийн хурал ном, ТЕГ-г хадгалагдаж буй Уулбаян сумын Өглөгийг бадруулагч хийд гэх мэдээ баримтуудаар тодруулан үзлээ.

Нутгийн хуучдуудын дурсамжид ...Хийд гурван дугантай, Жинбадаржаалин, Чойр гэсэн хоёр дацантай, гол шүтээн Махгал, өдөр бүр цогчэн хурдаг ⁹⁶хэмээжээ. Хутагтын хүрээний лам нар Их хүрээний Дугарын аймагт⁹⁷ аймаглан суудаг. Ринчинбадам хутагт хүрээнд ирж Гунгаачойлин дацанд зиндаалдаг байсныг нутгийнхан дурсан ярьдаг.⁹⁸ Дүүргэсэн эсэхийг нягт үзүүштэй. Иймийн учир хүрээндээ 1918 онд Ванчин Содномдагвын игчаагтай чойрын дацанг байгуулсан бололтой.

Нутгийн ардууд Орлойн мэргэн хутагтын хүрээг 1990 онд Сүхбаатар аймгийн Уулбаян сумын нутагт Дэчинчойнхорлин нэртэйгээр дахин сэргээж, хийд орон байгуулж, уламжлалт хурал номыг тус хүрээнд сууж байсан Жамбалсүрэн тэргүүтэй хуучны лам нарын зөвлөсөн ёсоор сэргэжээ.

Энэ тухай хийдийн тэргүүн лам Д.Жигмэджамц, лам Н.Наранбаатар нартай ярилцахад. ...Хийдийн гол шүтээн Гомбо (махгал) сахиустай. Их хүрээ дэгтэйгээр

⁹⁵ ТЕГ, тусгай архив Сан 1, Хөмрөг 5, Данс 1, ХН-431:70.

⁹⁶ Сүм хийдийн түүхэн товчоо төсөл,
<http://www.mongoliantemples.org/mn/monk-mn/568?view=oldtemplemn>

⁹⁷ Сэрээтэр Ө. Монголын Их хүрээ, Гандан хийдийн түүхэн бүтцийн товч (1651-1938), УБ.,2017:47

⁹⁸ Д.Амараатай 2024 оны 10 сар хийсэн ярилцлага. (Тэрээр Түвдэнпэлжээлин хийдийн ловон лам Ган-Очироос энэ түүхийг сонссон хэмээв.)

хурал номоо явуулдаг байсан. Уламжлалт цагийн хурлууд бүгд хурагддаг.⁹⁹ Онцлог хурлууд нэлээд бий хэмээгээд одоогийн хурлын горимоо ийн ярив. ...Өдөр бүрийн Цогчэн хурал хурна. Хурал дээр Орлойн мэргэн хутагт Ринчинбадамбын залбирлыг уншдаг. Сар бүрийн шинийн 8,15,29-ны хурлуудаа тогтмол хурж байна. Шинийн 5-нд Богд ламын ерөөл, 8-нд Их хүрээ дэгээр Маналаа хурдаг. Уламжлалт хурлууд нь Мэргэн хутагтын зүүдний хурал гэх Гомбо бурханы ганшаг (хангалт¹⁰⁰) Жамбий янжий¹⁰¹ номыг өвлийн тэргүүн сарын шинийн 10-нд шөнийн турш тогтмол хурдаг. Энэ хурал зөвхөн Мэргэн хутагтын хүрээнд хурдаг байсан. Шинэ жил гарахын урд гурван хоногт хуучин номын хурлаа хурж, битүүнд Найдан чоно, Цэдэрлхамын хурлаа хурдаг. Шинийн 1-ээс Их ерөөл хурахдаа арван хангалыг 9-ны өдөр хүртэл уншдаг. Үүнийгээ Цамба ес хэмээн нэрлэдэг. Энд, Жигжидийг өдөр бүр унших бол шинийн 2-нд Очирваань, 3-нд Гомбо, Гонгорыг цуг уншина. 4-нд Чойжоо, 5-нд Лхам, 6-нд Шалши, 7-нд Намсрай, 8-нд Жамсран, 9-нд Цамба уншаад, шинийн 10-аас 15-ныг гадаалтал Их ерөөлөө 6 хоног хурж Цагаан сарын хурал дүүрдэг. Ийн хурах нь хутагтын хүрээний уламжлал юмаа. Хаврын сард 3 хоног Маанийн чоно, зуны сард 3 хоног Санжидмоллом хурдаг. Зуны дунд сард Ганжуурыг нутгийн дээсээр эргэдэг, зуны адаг, намрын эхэн сарын аль нэгэнд Майдар эргэдэг. Намар Мэргэн хутагтын хүрээнд хурдаг, намрын түмт гэх Гомбо, Намсрай, Жамсрангийн хурал хурна. Эхний өдөр Гомбыг тахиад ган шагва (хангалт) буюу наманчлагыг түм тоолно. Дараагийн өдөр Жамсран тахиад мөн адил түм тоолно, гуравдах өдөр Намсрай тахиж, түм тоолоод хийдийнхээ даллага авснаар уг хурал дүүрдэг. Намрын адаг сарын 23-нд Бурхан багшийн эхийг ачийг хариулсан дүйчэн өдрийн хурлаа хураад оройноос нь 3 хоног Жанрайсэг бурханы үүднээс нүгнай сахидаг¹⁰² хэмээн өгүүлсэн¹⁰³-ийг Уулбаян сумын Өглөгийг бадруулагч хийд гэх баримтын мэдээтэй харьцуулж үзлээ. Хутагтуудын үйл хэрэг хэсэгт өмнө дурдсан учир хүснэгтээр харууллаа.

Хутагтын хүрээний анхны хувилгаан Лувсанжамба ...*Гомбо сахиусыг... өдөр бүр мөнхлөн хурж байхаар тогтсон*¹⁰⁴ үеэс Гомбо сахиус хутагтын хүрээний гол шүтээн болжээ.

⁹⁹ Шинийн 8,15,29-ны хурлууд

¹⁰⁰ Тэнгэр сахиусыг аргадах шашны зан үйл, догшин сахиус, Бүрнээ, Д. Энхтөр, Д. Төвөд Монгол толь, Улаанбаатар: Цээл-Эрдэнэ, 2001, 21. Наманчлах зан үйл, хангал Тэрбиш Л. Төвөд Монгол иж бүрэн толь бичиг, Улаанбаатар: Соёмбо, 2018, 95.

¹⁰¹ 20 шад ном

¹⁰² Нүгнай сахихын ёс ...Нүгнай гэдэг нь чилэн зовох гэсэн утгатай. Нүгнайг лам хуврагууд хүрээ сүм хийдэд болон гэр орондоо ч сахидаг байсан хурал ном юм. Хурлын гол утга нь нэг өдөр хоол унд идэлгүй, өлсөж ундаасан бирдийн зовлонг өөрийн биед авч, зовлонгоос гэтэлгэх их нигүүлсэнгүй сэтгэлийг үүсгэдэг. Мөн нэг өдөр үг дуу гаргалгүй, адгуусны зовлонг мэдэрч, адгуусны зовлонгоос гэтэлгэх их бодь сэтгэлийг үүсгэдэг. Харин 3 дахь өдөр нь халуун хүйтэн тамын зовлонг өөрийн биед мэдэрч, тамын амьтдыг тамаас гэтэлгэж, их нигүүлсэхүй сэтгэлийг үүсгэдэг. Ингэж хурал хурснаар 3 муу заяаны амьтдыг зовлонгоос гэтэлгэх төдийгүй тэнгэр, асури, хүнийг зовлонгоос гэтэлгэж Жанрайсэг бурханы үүднээс үйлддэг хурлын зан үйл, уншлага юм.

¹⁰³ Жигмэджамц Д, Наранбаатар Н нартай 2024 оны 9 сард хийсэн ярилцлага

¹⁰⁴ Монголын сүм хийдийн түүхээс ...(Баримт бичгийн эмхэтгэл), эмх. Б.Эрдэнэбилэг, Улаанбаатар: ТЕГ-ын хэвлэх, 2014, 174.

Хутагтууд	Үүсгэсэн хурал ¹⁰⁵	Одоо уламжлагдан ирсэн байдал ¹⁰⁶
Лувсанжамба	-Гомбо сахиусыг өдөр бүр мөнхлөн хурах	-Гомбо шүтээн
	Хутагт жанч халсны дараа - Манал хурлыг сар бүрийн 15-нд нэг өдөр хурах	- Сар бүрийн 8 Манал хурдаг
Лувсангэлэг	- Ганжуур 108 боть залж жилд нэг удаа 3 өдөр хурах	- Зуны дунд сард нутгийн дээсээр Ганжуур эргэж, хурал хурдаг
	Хутагт жанч халсны дараа - Дэлгэр ламиран, Түй зэрэг хурлыг сар бүрийн 12-нд хурах	
Лувсанжигмэддорж	- Жанрайсэгийн нүгнай жил нэг удаа 10 хоног хурах - Ерөөл хурлыг жилд нэг удаа 3 өдөр хурах - Гомбын дордов 4 өдөр хурах	- Намрын адаг сарын 23-наас 3 хоног Жанрайсэг бурханы үүднээс нүгнай сахина.
Дондовбал	- Санжидмолон жилд 2 удаа 3 өдөр хурах - Янгладомбо хурал	- Зуны сард 3 хоног Санжидмолон хурдаг.
Ринчинбадам	- Өдөр бүрийн Цогчэн мөнхөлсөн - Цэдэрлхам, Хуучин хангал, Ерөөл - Маанийн бүтээл, Гүнрэг - Майдар жилд нэг удаа	- Цогчэн - Хуучин номын хурал, Цэдэрлхамын хурал, Шинийн 1-ээс Их ерөөл, Цамба ес - Хаврын сард 3 хоног Маанийн чого - Зуны адаг, намрын эхэн сарын аль нэгэнд Майдар эргэдэг.

Дээрх бүгдээс харвал Жибзундамба хутагтын Их шавийн харьяа Голын долоон хутагтын нэг Мэргэн хутагтын хүрээг анх байгуулсан Лувсанжамба хувилгаан Их хүрээний лам нартай харилцаа холбоотой байсан бол Лувсангэлэг хутагтын үед албан ёсоор Их шавьд захирагдаж Их хүрээ дэгтэйгээр хурал номын үйл ажиллагаагаа явуулж байсан байна. Үе үеийн хутагтуудын мөнхөлсөн хурлууд өдгөө ч уламжлагдан хурагдсаар байгааг хүснэгтээс харж болохоор байна. Хурал номоо үүсгэхдээ онцлог дэг ёсоор дэглэн хурдаг байсныг Цагаан сарын Их ерөөл хурах зан үйл, Мэргэн хутагтад зүүдлэгдсэн гэх Гомбын ганшагийн ард уншдаг Жамбий янжий зэрэг хурлуудыг тухайлан хурах болсон зэргээс харж болох юм.

¹⁰⁵ Монголын сүм хийдийн түүхээс ...(Баримт бичгийн эмхэтгэл), эмх. Б.Эрдэнэбилэг, Улаанбаатар: ТЕГ-ын хэвлэл, 2014, 174-176.

¹⁰⁶ Д.Жигмэджамцтай 2024 оны 9 сард хийсэн ярилцлага

4. Орлойн мэргэн хутагтын харьяа отог шавь

Халхын ноёд 1639 онд Түшээт хан Гомбодоржийн хүү Занабазарыг гэгээн цол өргөмжлөн залсныг сурвалжид “...Монголын Жибзундамба блам Өндөр гэгээн Лувсандамбажалцан ...шаргачин туулай жил таван сүүдэртэй Халхын долоон хошуу бүгдээр Ширээ нуур хэмээх газар ширээнээ залж шар хүрээ хийн гэгээн цол өргөн¹⁰⁷ тахиж. ...Энэ ондоо дагалдаагаар гадаад газраас өөр өөрийн тайж албатаас гаргаж тусгаар лам, хар шавийг байгуулж өргөв”¹⁰⁸ ...Түшээт хан түүнд 7, 8 настай 108 банди нарыг шавь болгон өргөжээ. Түшээт хан нас барсны дараа ...гурван ах нь 70 гаруй сум ардыг хуваан аваад дүүдээ арав арав бүгд 30 өрх өгчээ. Занабазарын авга ах Дүүрэгч ноён бас хоёр өрх өргөж бүгд 32 өрх хүнээс Өндөр гэгээний харьяат шавь нарын үүсэл тавигдсан¹⁰⁹ хэмээн академич Ш.Нацагдорж үзсэн байдаг. Энэ үеэс монголын язгууртнууд өөрсдийн харьяат албатаас шавь өргөх болсноор хутагтын шавь нар олширч байсныг 1837 оны нэгэн баримтад ...гагцхүү Жибзундамба хутагт болбоос зарлигаар тусгайлан Халхын дөрвөн аймагт тахиулсан ихээхэн блам бусад бага сага хутагт нарт адилтгаваас болох үгүй. Хутагт угаас дагаар ирсэн шавь үгүй. Анхан дүрээс эдүгээ болтол олон Монгол хан, ван, засаг тайж нар шарын шашиныг эрхэмлэж ном хурлын хэрэглэлд туслуулахаар өөр өөрийн хамжлага албат, хошууны ардын дотроос дуртайг нь үзэж шавь болгосоор¹¹⁰ иржээ. Өргөгдсөн ардууд өөрийн төрсөн нутагтаа аж төрөн сууж, Их шавийн засаг захиргааны нэгж отог багт хуваарилагдан захирагддаг байв.

Дарьгангын таван гар сүрэгчдээс Жибзундамба хутагтын шавьд өргөгдөн Их шавьд захирагдах явдал их байжээ. Энд 3 баримтыг жишээ болгов. 1769 оны Дарьганга дахь адууны сүргийн Үхэри да-гийн хэргийг хамаарсан хиагийн бичигт ...манай адуун сүргийн хүн Номын далайн өргөсөн нь, Миний гэрийн хүн гэгцэл Наваандамбыг Жибзундамбын гэгээний шавь болгож барья хэмээсэн бүлгээ. Олдвоос уламжлан мэдүүлж тэмдэгт бичиг олгуулах ажаамуу.¹¹¹ 1790 оны Дарьгангын хонин сүргийн хамаарсан гарын тэргүүн Банзрагч нараас хонин сүргийн дарга Жигмэдийн мэдүүлсэн нь ...Жигмэд миний гэрийн хүн Мөнх эмтэй, түүний хөвгүүн хувраг Намжав, хар Дондог, охин нэг бүгд таван ам нэг өрх. Мөнхийн ахмад хөвгүүн Гончигжав эмтэй өсвөрийн хөвгүүн Говид, Болд бүгд дөрвөн ам нэг өрх. Мөнхийн бага хөвгүүн Гомбо, эмтэй хоёр ам нэг өрх. Мөнхийн төрөл хувраг Шарав, түүний эх, охин дүү бүгд гурван ам нэг өрх.

¹⁰⁷ Богдын уг эх товч 76 тал МҮНС, Монгол судлал, гар бичмэлийн сан хөмрөг, 48/96

¹⁰⁸ Богд Жибзундамбын анхан төрлийн нэр оршвой орон дацан анхан байгуулсныг бичсэн буянаар бурханы шашин өнө үүрд орших болтугай. Монгол улсын шастир (дэд дэвтэр), Улаанбаатар: Соёмбо, 2006, 413.

¹⁰⁹ Нацагдорж Ш. Монголын феодализмын үндсэн замнал (Түүхэн найруулга), Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1978, 202.


¹¹⁰ Нинжбадгар З. Жибзундамба хутагтын шавийн захиргаа (XVIII-XX зууны эхэн), Улаанбаатар: Арвин судар, 2014, 15.

¹¹¹ Дарьгангын түүхэнд холбогдох баримтууд (Баримт бичгийн эмхэтгэл), эмх.Т.Билэгсайхан, Улаанбаатар: Соёмбо, 2020, 60.

Шаравын дүү Чимэддорж эмтэй хоёр ам нэг өрх. Бүгд арван зургаан ам таван өрх хүнийг Тэнгэрийг тэтгэсэний тавин таван он, найман сарын хорин гурванд Жигмэд би дуртай Жибзундамба гэгээнтний шавь болгон өргөсөн.¹¹² 1826 оны Хонин сүргийн да-гаас Мэргэн бандида ламтны өргөөний газар, хэргийг мэдээгч тэргүүн ламтны газарт ...манай Хонин сүргийн харьяат Байшинт сүмийн тэргүүн лам Лувсан-Ишнэмын өргөн мэдүүлсэн. Манай сүмийн харьяат хувраг Балжирын төрсөн ах мэйрэн Шагдарын мэдүүлэн гуйж ирсэн нь, Урьд миний эцэг амьд байх цагтаа түүний банди Балжирыг нялхад Мэргэн бандида ламтны авралд багтаан өргөө хэмээсэн бөгөөд, эдүгээ хүсэн батлах бичиг олгуулахыг гуйя хэмээн мэдүүлэн иржээ. Хянаваас Мэргэн бандида ламтнаа өргөө хэмээх санаа үнэнхүү тул, ...хувраг Балжирыг бат тэмдэг бичиг олгосугай¹¹³ зэргээр Жибзундамба хутагт, түүний харьяа Орлойн мэргэн хутагтын шавьд захирагдаж байсан байна. Энэ мэтчилэн Дарьгангын сүрэгчид болон ойролцоох хошуудын ардууд Их шавьд захирагдах болсноор Орлойн мэргэн хутагтын отог бүрэлдэн буй болсон ажээ.

Жибзундамба хутагтын шавийнхан Халх дөрвөн аймгийн нутагт чөлөөтэй нутаглах эрхтэй, аль аймаг хошуунаас өргөгдсөн тэр нутагтаа нутаглан аж төрдөг байсан. Хоёр отгийн шавь нар ихэвчлэн Жанжин Эрхт гүн Пунцагдалайнамжилын¹¹⁴ нутагт нутаглаж байв. Иймээс өдгөө Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Түвшинширээ Уулбаян сумдад өөрсдийгөө Орлойнхон гэж нэрлэдэг хүмүүс олон байдаг. Тэд Их шавийн харьяат Орлойн мэргэн хутагтын шавь нарын хойчис билээ. Хутагтын орон хийд Дарьгангад боловч отог шавь нар Сэцэн хан аймгийн Эрх гүний хошуунд нутаглаж байсныг дор өгүүлнэ.

Зураг 5



Эх сурвалж: Пүрэв.О, XX зууны эхэн үеийн Ар Монгол (1900-1930)

¹¹² Дарьгангын түүхэнд холбогдох баримтууд (Баримт бичгийн эмхэтгэл), эмх.Т.Билэгсайхан, Улаанбаатар: Соёмбо, 2020, 60.

¹¹³ Дарьгангын түүхэнд холбогдох баримтууд (Баримт бичгийн эмхэтгэл), эмх.Т.Билэгсайхан, Улаанбаатар: Соёмбо, 2020, 61.

¹¹⁴ МУУТА, X-179 Д-1 ХН-31.

1845 он болоход ...Блам Лувсангэлэгийн хувилгаан 1 отгийн 100 илүү өрх шавьтай¹¹⁵ гэсэн бол Жигмэддоржийн (1790-1853) үед бичигдсэн нэгэн баримтад ...өөрийн харьяат 900 илүү шавьтай¹¹⁶ гэх мэдээнүүд үлджээ. Олноо Өргөгдсөн Монгол улсын үед хутагт хоёр отог шавийг захирах болсон байна. XX зууны эхэнд Мэргэн хутагтын шавь отог хэдэн өрх ам байсныг хүснэгтээр үзүүлээ.

Хүснэгт 3

1912, 1915, 1918, 1921, 1918,¹¹⁷ он Орлойн мэргэн хутагтын шавь
отгын өрх ам, малын тоо

Отог	1912	1915	1918	1921	Майский
Орной зайсан дарга ---1912 онд Дугар, ---1915, 1918, 1921 Цэвээнжав					
Лам	116	127	193	177	193
Өрх	61	62	70	70	-
Ам	418	442	570	537	Эрэгтэй 50-иас дээш нас 25 18-50 насны 28 18 хүрэх 5 Эмэгтэйчүүд охид 522 Нийт лам, хар 773
Тэмээ	82	65	44	8	51
Адуу	198	189	146	42	172
Үхэр	177	108	113	48	208
Хонь	960	456	899	176	378
Сэвэг ¹¹⁸	6	4	4	1	
Сул	205	140	580	175	
Орной зайсан дарга ---1912, 1915 онд Загд, ---1918, 1921 Жамсран					
Лам	79	82	90	96	90
Өрх	26	28	20	24	-
Ам	213	204	199	208	Эрэгтэй 50-иас дээш нас 10 18-50 насны 5 18 хүрэх 2 Эмэгтэйчүүд охид 179 Нийт лам, хар 286
Тэмээ	117	205	82	7	

¹¹⁵ Алтанзаяа Л. Их шавийн отгийн тухай нэгэн мэдээ, *Халхын мэргэн То ван, Эрдэм шинжилгээний цуврал бичиг*, №30, 2005, 48.

¹¹⁶ *Дарьгангын түүхэнд холбогдох баримтууд* (Баримт бичгийн эмхэтгэл), эмх.Т.Билэгсайхан, Улаанбаатар: Соёмбо, 2020, 60.

¹¹⁷ МУУТА, А-74 Д-1 ХН-48, 327, 508, 662, Майский И. *Орчин үеийн Монгол (Автономит Монгол XX зууны гараан дээр)*, Орос хэлнээс орч. Ц.Отхон Улаанбаатар: Согоо нуур, 2001, 14.
Жич: Орной (Орлойн) отгийг Орхон хэмээн буруу буулгажээ.

¹¹⁸ Их шавийн алба татварын нэгж цай. Цайг сэвэг сул гэж хуваадаг. Сэвэг цай 800 ширхэг задгай цайг хэлэх ба 800 үл хүрэхийг сул цай гэнэ.

Их шавийн Орлойн мэргэн хутагт

Адуу	274	208	200	56
Үхэр	248	147	103	28
Хонь	1946	429	652	165
Сэвэг	10	6	4	1
Сул	200	200	740	105

Хүснэгтээс отгийн өрх амын доторх лам нарын эзлэх хувь, малын өсөлт, бууралтыг харж болно. Дээрх 4 тооллого баримтад Орлойн мэргэн хутагтын 2 отогт 90 гаруй өрх 700 гаран шавь ард захирагч байжээ. 1921 оны тооллогоор малын тоо толгой эрс буурсан нь дээрэм тонуулд мал сүргээ алдсан, шинэ тулгар байгуулагдсан төрөөс хүн ам, малын бүрэн тоог дарж нуусан, нутаг сэлгэн нутагласан малчдын тоо ороогүй зэрэг олон шалтгаанаар үнэн бүртгэл хийгдээгүй байдаг.

Ардын Засгийн газар 1922 оноос орон нутгийн хуучин захиргааг шинэчлэх, нутгийн захиргааг ардчилах ажлыг эхлүүлсэн. Энэхүү ажлын хүрээнд нутгийн захиргааг шинэчлэн байгуулах, хурал нээх, хурлын төлөөлөгчдийг сонгох шийдвэрийг 1923 оны 3 сарын 23-нд баталсан.

Монгол улсын нутгийн захиргааны дүрэм 6 бүлэг 58 зүйлтэй. Дүрмийн 1-р зүйлд *Бидний Монгол улс нэгэнт ардын эрхтэй хэмжээт цаазат улсын засгийг байгуулсны тулд, арван гэрээс дээш баг, сум, хошуу, аймаг улсын засгийн газар хүртэл тус тусын ардын төлөөлөгчдийг сонгон хуралдуулж, дэс дараалан хурал байгуулан, элдэв хэрэг зүйлийг шүүмжлэн хэлэлцүүлж, олонхын саналаар таслан тогтоож, ардын эрхийг эрхэмлэн хүндэтгэвэл зохино*¹¹⁹ хэмээн орон нутгийн засаг захиргааг арван өрхөөр нэг арван, 50 өрхөөр нэг баг, 150 өрхөөр нэг сумтай байхаар зохиосон ба энэ ажлын хүрээнд 1923 оны 7 сарын 8-ны өдрийн Ардын Засгийн газрын 25-р хурлаар Их шавийн захиргааны дүрмийг баталсан. Хуучин засаг захиргааны нэршлийг газар усны нэрээр солих шийдвэрийг 1923 оны аргын 10 сарын 19-ны өдрийн Ардын Засгийн газрын 38 хурлаар баталснаар Их шавийн 160 отог 29 багийг 82 отог, 7 баг¹²⁰ болгон цомхотгож газар усны нэрээр нэрлэх болсноор Орлойн мэргэн хутагтын шавь 2 отгийг Баянмөнх уулын отог болон нэршил нь өөрчлөгджээ.

¹¹⁹ Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл, II боть, Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2010, 432-433.

¹²⁰ МУУТА, X-179 Д-2 ХН-82.

1924 он Мэргэн хутагтын шавь отгын өрх ам, малын тоо¹²¹

Отог нэр дарга	өрх	Лам банди	18 дээш 45 хүртэл	45 дээш	18 доош хүү	Эмс охид	Эр эм бүгд	Адуу	Тэмээ	Үхэр	Хонь	Ямаа
Баянмөнх уулын отог Жамсран	182	291	129	19	122	625	1186	4768	703	2667	23531	1834
Төл мал								Унага 554	Ботго 45	Тугал 468	Хурга 6810	Ишиг 380

Уг баримтад өрх амын тоо эрс өссөн нь бусад отгуудтай нэгдсэнийх аж. Их шавийн ямар отгууд нэгдэж Баянмөнх уулын отог болсныг нягтлан үзүүштэй.

Шавь нарын үндсэн үүрэг нь Тахилын цай тэргүүтэй бусад албыг хутагтын сан болон шавийн харьяа сүм хийдийн хурал номын хэрэглэлийг бэлтгэн гаргах юм. Энэ тухай Дээрхийн уг эх сурвалжид дурдсанаар, *...олон шавь нар цөм огт алба үгүй гагцхүү Жибзундамба ламын санд алба барьж шарын шашины хэрэглэл гаргасаар иржээ.*¹²²

Их шавийн захиргаа Эрдэнэ шанзудбын яам 3 жил тутам өрх ам, малын тооллого явуулж малын хөлд таацуулан Тахилын цай тэргүүтэй бусад албыг отгийн малчид оноодог. Харин Орлойн мэргэн хутагт тэргүүтэй голын долоон хутагт Их санд цай зэрэг алба барьдаг үгүй албанаас чөлөөлөгдөхийн хамт, отог шавь нарыг тусгайлан захирч, шавь нар хутагт болон харьяа сүм хийддээ алба барьдаг. Жибзундамба хутагтын Их сан хутагтын хүрээний сүм хийдийн тодорхой зардлыг гаргадаг, онцгой эрхтэй байсан.

Хутагтын шавь нар Жибзундамба хутагтын Их сан, хутагт жанч халах, ширээнд залах, шинэ сүм хийд байгуулах, Бат-Оршил өргөх зэрэгт алба татвар өгөхийн хамт харьяа хутагтад захирагдах отгууд тухайн хутагтын сан, сүм хийдийн хурал ном, сүм хийдийн шинээр барих, сэргээн засвар зэрэгт алба татвар өгдөг.

¹²¹ МУҮТА, Х-179 Д-2 ХН-82.

¹²² Дээрхийн уг эх. тэргүүн дэвтэр, МҮНС, гар бичмэлийн номын фонд.1575/96, 19.

Орлойн мэргэн хутагтын шавьд тос, цай, мөнгө оноосон байдал

Он	Олго	Тахилын сэвэг цай	Сул цай	Тос жин	Тос бан	Саалийн үнээ	Даншгийн мөнгө зэрэг 6 зүйлийн үндэс хураах цай	Зоог тахил ба хурал номын элдэв хэрэгцээнд хураах мөнгө	Дээрх албанаас
1915	Орной дарга Дугар	4	140	880	0	7	3200	1600	8 сул цай, тос 1 жинг Мэргэн хутагтад хэрэглүүлнэ. 10 сул цай, Тос 1 жин Давхарын мөнгөнөөс 160 ланг Өглөгийн бадруулагч хийдэд баримуй.
	Мөн дарга Загд	6	200	1375	0	11	500	2500	5 сул цай, тос 1 баныг Хурдан даяанчийн хувилгаанд хэрэглүүлнэ
1918	Орной Цэвээнжав	4	580	915	0	6	3660	1512	10 сул цай, тос 1 жин 1 банг Мэргэн хутагтад 13 сул цай, тос 1 жин 1 бан, даншгийн мөнгөнөөс бусад хөлийн албаны үнээс 6 цайг, зоог хурал номын мөнгөнөөс 160 ланг Өглөгийг бадруулагч сүмд
	Орной Жамсран	4 үүнээс	740	985	0	7	3940	1576	Хурдан даяанчийн хувилгаан Очирбатын хэрэглэх 6 сул цай, тос 1 жиг

Орлойн мэргэн хутагтад Олноо Өргөгдсөний 3 онд (1913) *Мэргэн хутагт 50 сул цай*¹²⁴ барьжээ. Мөн Их хүрээ дэх Сажныг бадруулагч сүмийн хурал ном хуврагийн хэрэгсэлд цай тос барих үүрэг хүлээдэг. 1838 онд ...*Орнойн дарга Батжаргалын отог 6 сэвэг, 305 сул цай, 262 жин тос*¹²⁵ тушаасан. Энэ мэтчилэн 2 отгийн ард алба гаргах үүрэгтэй.

Харин Өглөгийг бадруулагч сүмийн хурал номын хэрэгцээнд Их сангаас тогтсон тоогоор цай тос олгодог. Тухайлбал, 1863-1910 онуудад ...*хувилгаан блам Лувсангэлэгийн байгуулсан Өглөгийг бадруулагч буюу Жинбадаржаалин сүмд сэвэг 2, шар тос 71 жин*¹²⁶ өгч хэрэглүүлдэг байсан байна.

¹²³ МУУТА, А-74 Д-1 ХН-513, МУУТА, А-74 Д-1 ХН- 329.

¹²⁴ МУУТА, А-748 Д-1 ХН-152.

¹²⁵ МУУТА, М-85 Д-1 ХН-416.

¹²⁶ МУУТА, М-85 Д-1 ХН-805, 944, 1026, 1164, 1220, 1227, 1308, 1502.

Отгийн ардуудаас өөрийн хүсэлтээр хутагтын сан, Өглөгийг бадруулагч хийдийн сүрэг малыг хүлээн авч сүргийг осол эндэлгүй хариулж, тоо толгойг нь нэмэгдүүлэх үүрэг хүлээдэг байсан. Жишээлбэл, 1918 онд Өглөгийг бадруулагч хийдийн малыг Хар Гүндэн адуу 121, ажиг Дугар үхэр 39, хонь 727, увш Рэгдэл тэмээ 4, адуу 4, үхэр 58, хонь 740, хувраг Рилдэ тэмээ 21, адуу 4, үхэр 57, хонь 626, хар Шагдар үхэр 98, хонь 649¹²⁷-ийг маллаж байжээ.

Дээрх бүгдээс дүгнэн үзвэл Их шавийн голын долоон хутагтын нэг Орлойн мэргэн хутагт нь 90 гаруй өрхийн 700 гаруй шавь нарыг захирч, Их шавийн Өглөгийг бадруулагч хийдийг тэргүүлэн суудаг. Мэргэн хутагтын хүрээний хурал номын зардлыг Жибзундамба хутагтын Их сан, Орлойн 2 отог гаргадаг. Шавь нар Жибзундамба хутагтын Их сан, харьяа сүм хийдүүдийн зардлыг гарах үүрэг хүлээн Эрдэнэ шанзудбын яаманд харьяалагдаж байсан.

5. Дарь овоог тайх хэргийн тухайд

Чин улсын Энх-Амгалан хаан зарлигаар 1697 онд Дарьганга нутагт цэргийн зориулалттай төмөр сүргийн захиргааг байгуулжээ.

Энэ хэсэгт сүрэгчний нутаг дахь Дарь овоог хэзээнээс тахиx болсон, тайх хэргийг Жибзундамба хутагтын Их шавь эрхлэн мэдэх болсон асуудлыг тодруулах үзье.

Дарьганга нутгийн уугуул ардууд уг уулыг хэдий үеэс тахиж шүтэж ирсэн нь тодорхойгүй ч энэ түүхийн судалгаа хийсэн. Л. Жамсран ...Гэрсэнз хунтайж нас барахад түүний хатан 7 хүүдээ өмчөө хуваахдаа тавдугаар хүү Дарьдаа Хатиган Хөхийдийг өгсөн. ...Иймд Дарьганга нутаг XVI зууны үед Дарь ноёны захиргаанд байжээ. Дарь ноён түүний хатантай холбоотой байж болох юм. Дарь овооны зүүн бэлд Ноён хөрөг Хатан хөрөг гэж нэг дороо хоёр гантиг чулуун суугаа хөрөг бий. Тэдгээрийг нутгийн оршин суугчид ихэд хүндлэн идээ цагааны дээжээ өргөдөг заншилтай. Дарь овоо байгаа уулыг Захын хар өндөр гэж урьд нэрлэж байсан мэдээ бий. Тэгвэл нутаг Дарь ноёны харьяанд орсноос хойш захын Хар өндөр гэдгээ больж Дарийн нэрээр нэрлэгдсэн байж магадгүй.¹²⁸ Т.Билэгсайхан ...1696 онд Дарьганга нэртэй байсан явдал нь хожим Дарь овоо хэмээн нэрлэсэн гэвэл өрөөсгөл болно. Харин яагаад уул, нуурын нэр байхад нутгийн ард Захын хар өндөр хэмээн нэрийдэж байгаа гэдэг нь уулаас монголчууд уулын нэрийг шууд нэрлэдгүйтэй холбоотой юм. Тэхээр XVII зууны дунд хэрд нэрлэгдсэн Дарь уул, Ганга нуурыг нутгийн ард бишрэн хүндэлж хайрхны нэрийг шууд хэлэхийг цээрлэж дүйвүүлэн Захын хар өндөр хэмээн нэрлэж байгаад хожим тайх болсонд Алтан овоо хэмээн өргөмжлөн нэрлэх болжээ¹²⁹ хэмээжээ. Судлаачдын дэвшүүлсэн саналд тал өгч болмоор аж. Ямартай ч нутгийн ардын тахиж шүтэж ирсэн Дарь уулыг Дарьганга нутагт Манжийн хааны сүрэг адгуулах болсон

¹²⁷ МУУТА, А-74 Д-1 ХН-701.

¹²⁸ Жамсран Л. *Дарьганга*, Улаанбаатар: ,1999, 6.

¹²⁹ Билэгсайхан Т. *Дарьганга түүхийн тойм XVII зууны сүүлээс XXI зууны эхэн*, Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2015, 19.

үеэс эсэн мэнд өсгөн үржүүлэхэд байгалийн гамшиг, өвчин эмгэг, гарз хохирол тохилдохоос сэргийлэх, сүрэгчид амар амгалан сайн сайхан аж төрөхийн тухайд газар орныг аргадан нийтээр тахин шүтэх болсон аж.

1757 онд сүргийнхэн II Жибзундамба хутагтад айлтган Дарь овоог тайлгах сайн лам гуйсанд, уул нутагт шашин ном дэлгэрүүлж байсан Мэргэн Нансо-гийн хувилгаан Лувсангэлэгийг сүргийн газар ном уншуулах, Дарь овоог тайлгах ламаар томилсон. Уг шийдвэрийг Тэнгэрийг тэтгэсэн хаанд айлтгаж, зөвшөөрснөөр ...жил бүрийн хаврын эхэн сар ба зун хоёр удаа¹³⁰ тахих болсон байна.

Голын долоон хутагтаас хамгийн сүүлд Их шавь захирагдсан хутагт бол Мэргэн хутагт юм. Дарьганга нутаг Сэцэн ханы эзэмшилд байсныг хааны зарлигаар захиргааг Чуулалт хаалга (Чжанцэяоу, Жанчхүү, Хаалган Г.Б.) суудаг Гусай амбан (хошуу захирагч сайд)-гийн газар¹³¹ -т шилжүүлсэн. Өөрөөр хэлбэл Халх дөрвөн аймгийн захиргаанаас тусгаарлан, Манжийн хааны шууд мэдлийн нутаг болсон. Энэ нутагт Жибзундамба хутагт, Их шавийн захиргаа өөрийн харьяат хутагтыг суулган шашин номын үйлийг тэргүүлэн ажиллаж болсон нь санаандгүй хэрэг биш байсан болов уу? Дарь овоог тайх хэргийг Их шавиас зохион байгуулж, Мэргэн хутагтууд удирдан тахих үүрэг хүлээсэн. Өмнө өгүүлснээр Орлойн Мэргэн хутагтын шавь отгийнхон Дарьганга нутагт нутаглахгүй, хил залгаа Эрх гүний нутагт нутаглаж байсан нь Жибзундамба хутагтын шавь нар Халх дөрвөн аймагт дураар нутаглах эрхтэй байсных юм. Жибзундамба хутагт Дарьгангад харьяат хутагтыг суулгасан нь шашны хувьд мэдэж байх гэснийх болов уу?

Иймээс нутгийн тахилгат уулыг хааны зарлигаар байнга тахидаг уул болгож, Батцагаан хэмээх дугуй цагаан сувраг барьж, орой дээр нь алтадсан зэс ганжир сүншиглэн залснаар Алтан Дарь овоо (Алтан овоо) гэгдэх болжээ.

Жигмэддорж хутагт VII Банчин эрдэнэ -д айлтгал өргөн *“Газрыг баригч Дарьганга орны эзэн буяны садан нөхөр сэлтийн илт онол, урилга заллага, хангал наминчлал бүрэн бүрэлдсэний соёрхол тахилга оршвой”* гэх Алтан овооны Сан судрыг зохиолгосон. Уг судрын төгсгөлд *...Энэ адил нэг хэрэгтэй хэмээн Эрдэнэ Мэргэн хутагтын хувилгаан Лувсанжигмэддорж хийгээд Равжамба Лувсанбалжор хоёр бээр дуртадгасны хариуд шагжийн гэлэн Лувсанбалданданбинямчоглайнамжалбалсанбо найруулсан болой.*¹³² гэсэн байдаг. Мөн Алтан овооны газрын эзний дүрийг бүтээж айл бүр тахиж шүтэх болсон байна.

Орлойн хутагтууд Алтан Дарь овоог жил бүрийн хаврын эхэн сар ба зун хоёр удаа тахидаг. Тахилгад сүргийн Бүгдийн тэргүүн, гарын тэргүүн, олон да, мээрэн нар болон бусад эрх баригч эрх дархтан, бүх сүм хийдийн тэргүүн, дэд хамба, да лам тэргүүтэй олон хуврагууд, ард олон хүрэлцэн оролцдог. Лам нар Батцагааны урд тахилгын уншлага, овооны магтаал зэргийг уншиж хэнгэрэг цан нижигнүүлж

¹³⁰ Жамсран Л. *Дарьгангын сүрэг хошуу*, Улаанбаатар: Эрдэм, 1994, 11.

¹³¹ Жамсран Л. *Дарьгангын сүрэг хошуу*, Улаанбаатар: Эрдэм, 1994, 10.

¹³² Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын харьяат А.Гомбод хадгалагдаж буй Алтан овооны сангийн судар

байхад нутгийн сайн хуурч, морин хуурын эгшигд Дарь овооны магтаалыг аялан хэлж цугларсан олныг баясгадаг.¹³³ Магтаалд:

Богд л Дарь овоо минь

Богд эзэнд мэдээтэй

Бойгон журганаас цалинтай

Баруун зуугаас сургаалтай

*Банчин Богдоос лүндэнтэй*¹³⁴ зэргээр өгүүлнэ.

Магтаалд гарч буй ...”Богд эзэнд мэдээтэй” Манжийн эзэн хаанд зөвшөөрөгдсөн, “Бойгон журганаас цалинтай” Сангийн яамнаас цалин авдаг, “Баруун зуугаас сургаалтай” Төвөдийн Лхасаас сургаал заавар авдаг, “Банчин богдоос лүндэнтэй” Банчин-Эрдэнэ тус овооны тухай зарлиг буулгасан¹³⁵-ыг өгүүлжээ.

1911 онд Монголчууд төрийн тусгаар тогтнолоо сэргээн мандуулахад Дарьгангачууд 1912 онд Олноо Өргөгдсөн Монгол улсад нэгдсэн, Богд хааны зарлигаар Дарь овоог хуучин ёсоор тайлгах болсон байна. Олноо Өргөгдсөний 3 (1913) оны Дотоод Хэргийг Бүгд Захиран Шийтгэх Яамны нэгэн бичигт ...эдүгээ Дарьганга дахь дарь овоог жил бүр хуучин удаагаар тайлгаар буулгасан Дээд Зарлигийг хичээнгүйлэн дагаж, энэ он намар цаг тайлгахад цагийг сонгон үзүүлбээс, энэ намрын дундад сарын арван хоёрны баасан гараг гал бичин өдөр луу цагт тайлгаваас сайн хэмээсэн, Зарлиг ёсоор ...Тайх зарлиг тайлгын хүж, торго, сумыг өртөөгөөр хүргүүлсүгэй, ...Зарлигийн бичиг, тайлгын хүж, торго, сумыг хүрмэгц, хичээнгүйлэн хүлээн авч, харьяат нутагт бүхий Дарь овоог зарлигаар тайх удаа бүр тайлгыг эл хэрэглэл зүйлийг хуучныг мөрдөж, таван гараас нийгэмчлэн ариун цэврийг гаргуулж, Их шавь мэргэн хутагт Ринчэнбадамыг урин авчирч, бүгдийн тэргүүн биеийг мөнхүү таван гарын түшмэдийн хамтаар сонгон үзүүлсэн өдөр цагт тайх Овооны газар одож, ном уншуулж, зарлигийг дуудаж, хүж, торгог толилж, сумыг Овоонд өргөж, сайнаар тайж үүрд хичээнгүйлэн дагаж явуулбаас зохихын гадна, урьд нэг жилд аль аль улиралд хэдэн удаа тайдаг явдлыг бүгдийн тэргүүний газраас тодорхойлж мэдүүлэн сонгон айлтгаж, зарлигийн бичиг, тайлгын хүн, торго, хүргүүлэхэд байцаах тэмдэг болгосугай. Үүнийг бас Нийслэл хүрээний Эрдэнэ шанзудба нарт тушаан явуулаад, харьяат мэргэн хутагт Ринчэнбадамд тушааж, Дарь овоог Зарлигаар тайлгахад удаа бүр биеэр одож тайх ном уншуулан дагаж явуулъя¹³⁶ хэмээжээ.

Ийнхүү Их шавийн Мэргэн хутагт, бүгдийн тэргүүний бие таван гарын түшмэдийн хамт албан ёсоор хавар, зуны цагт тахихдаа, сум торго хүж зэргийг Сангийн Хамаг Хэргийг Бүгд Захиран Шийтгэх яамнаас бэлтгүүлж бусад зүйлийг Дарьгангын харьяат газраас гарган гүйцэлдүүлдэг байв. Дарь овоог тахих хэргийн зардлыг сүрэгчдээс гаргадаг. Тухайлбал, ...хэрэглэх зүйлийг хэргийн ёсоор Дарьганга сүргийн хошуудаас Сэцэн хан аймгийн өмнө захад нүүдэл нь

¹³³ Жамсран Л. Дарьганга, Улаанбаатар: 1999:32-33.

¹³⁴ Урангуа Ж. Дарьганга, Түүх судлалын жимээр (Өгүүллийн эмхтгэл) Улаанбаатар: Соёмбо, 2014, 159.

¹³⁵ Урангуа Ж. Дарьганга, Түүх судлалын жимээр (Өгүүллийн эмхтгэл) Улаанбаатар: Соёмбо, 2014, 160.

¹³⁶ Дарьгангын түүхэнд холбогдох баримтууд (Баримт бичгийн эмхэтгэл), эмх.Т.Билэгсайхан, Улаанбаатар: Соёмбо, 2020, 345.

ирсэн түшмэд, ардаас зохисыг үзэж зөвшин татан бэлтгүүлэхээр мөн сүргийн түшмэл Цэрэнтогтохоос ...тайх тухайн эл хэрэгсэх зүйл ба майхан, ачлага, уналга, шүүс хүнс тэргүүтнийг бүртгэн хүлээн авч харьяат хутагт лам нарын ...хамтаар тайх овооны газар¹³⁷ирэх. Мөн ...гүн Магсаржаваас Дарь овоог тайлгахад хэрэглэх архи бага сав хоёрыг авхуулахыг эрснийг ёсоор болгон¹³⁸ явуулах зэргээр гаргадаг байв.

Эл нутгаас төрсөн түүхч Л.Жамсран 1923 оны 9 дүгээр сарын 12-нд хийсэн намрын тахилгыг “Дарьгангын сүрэг хошуу” номдоо бичжээ. ...Хүрээнээс хонин сүргийн гарын тэргүүн, Ерөнхий захирах яамны дэс түшмэл улсад туслагч гүн Магсаржав Богд хааны зарлигийг хүргэж очсон. ...Түшмэл хааны зарлигийг дуудаж хүж торго шатааж сум хадаг тэргүүтнийг овоонд өргөдөг. Сүргийн Да тус бүр тахилгат идээ цонхор, шан бай урьд адил авч очсон. Дарьгангын сүм хийдийн лам нар Овоон сүм дээр очиж хурал хурсны дараа Орлойн мэргэн хутагтын залж овоон дээр очдог. Ноёд овооны урдуур сууна.мэргэн хутагт овооны баруун талд майхан олон шавь нартайгаа ном уншиж хэнгэрэг цан тасралтгүй нижигнэнэ. Ийм ажиллагаа 2-3 цаг явагдаад ардууд овооны зүүн урд буй ноён хатны хөрөгт хадаг тавьж мөргөхөөр очдог. Тэгэхэд банди нар хадгийг булаан авч өвөртөлдөг.Үдээс хойш овооны баруун урд наадам эхэлж ганц их насны морьд уралдаж бөх барилддаг. Тахилгын төгсгөлд овоог гурван замаар ¹³⁹гороолсноор тахилга дүүрдэг байжээ.

Зуны тайлгаар томоохон наадам хийдэг. Дарь овоог ...зарлигаар тайлгаж, басхүү ялдарт бөмбөг намнуулан, сур харвуулж наадам үйлдэх, ...бөх, харваач жич хэрэгсэх зүйлийг урьд Дотоод яамны тогтоосон ёсоор хэдэн этгээдээр гүйцэтгэх эс бөгөөс хуучин өнгөрүүлж явсан удаагаар ойр аймаг шавиас¹⁴⁰гүйцэтгэн гаргуулдаг байв. Наадамд оролцох бөхчүүд Овоон сүм дээр бөхийн бэлтгэл сорилгоо хийж Дарь овооны тахилга наадамд оролцох эрх авдаг байсныг судлаачдын бүтээлд дурдсан байдаг.¹⁴¹ Тахилга наадмаас олон алдар цуутай

¹³⁷ Дарьгангын түүхэнд холбогдох баримтууд (Баримт бичгийн эмхэтгэл), эмх.Т.Билэгсайхан, Улаанбаатар: Соёмбо, 2020, 346.

¹³⁸ Дарьгангын түүхэнд холбогдох баримтууд (Баримт бичгийн эмхэтгэл), эмх.Т.Билэгсайхан, Улаанбаатар: Соёмбо, 2020, 346.

¹³⁹ Жамсран Л. Дарьгангын сүрэг хошуу, Улаанбаатар: Эрдэм,1994, 28.

¹⁴⁰ Дарьгангын түүхэнд холбогдох баримтууд (Баримт бичгийн эмхэтгэл), эмх.Т.Билэгсайхан, Улаанбаатар: Соёмбо, 2020, 350.

¹⁴¹ Дарьганга дахь Дарь овооны наадамд барилдаж байсан хүчит бөхчүүдийн үүх түүхийг Б.Батсүх, Л.Ням-Осор нар “Монгол бөхийн хөгжилт” номдоо тодорхой бичсэн байдаг. Энд: Бөхчүүдийг тахилга болохоос өмнө сарын хугацаагаар хатуу дэг журамтай бэлтгэл хийлгэдэг байсныг нутгийн ардууд хуучлан ярьдаг. Жишээлбэл, бөхчүүдийг ...эхний хэдэн хоногт барилдуулахгүй, үнээний түүхий сүүний тос нь хөвөрсөн шингэн хоормог өглөө орой уулгаад өдөр нь махан хоол идүүлж, үргэлжлэн унтуулж харшааг нь арилгадаг байжээ. Дараа нь бөхчүүдийг дэвүүлээд гүйлгэдэг. Дэвэлтийн зайг өдрөөс өдөрт холдуулж дэвсний дараа шавах өрөх дасгалыг дэвэлтийн нэгэн адил үргэлжлүүлэн хийлгэнэ. Энэ үеийн сүүлчээс юм өргүүлэх, бөөрөнхий модон дээгүүр явуулах дасгалаар хүчийг нэмэгдүүлж, биеийн тэнцвэрийг олгодог. Бэлтгэлийн сүүлд мэх хийх хариулж сургах зэргээр үе шаттай бэлтгэл хийдэг байсан. (Батсүх, Б., Ням-Осор,Л. Монгол бөхийн хөгжилт. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар,1989,75-76.)

бөхчүүд төрөн¹⁴² гарсныг судлаачид бичсэн. Ийнхүү Мэргэн хутагтууд Алтан дарь овоог ёслол төгөлдөр тахиж ирсэн уламжлал өнөө ч үргэлжилж 2004 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн тахилгат уул болгосон билээ.

Дүгнэлт

Голын долоон хутагтаас хамгийн сүүлд Их шавьд захирагдсан хутагт бол Дарьгангын Орлойн мэргэн хутаг юм. Тэд Халхын шашны эзэн Жибзундамба хутагтын шавьд захирагдан, Алтан дарь овоо тайх үүргийг хүлээн, Мэргэн хутагтын хүрээгээ удирдан шашин номын үйлийг эрхэлж байсан агаад Дарьганга нутаг дахь хамгийн нөлөө бүхий хутагт байсан байна. Хутагтын хүрээ 199 орчим жил Дарьганга дахь шашин номын төв болон оршсон аж.

Хутагтууд хийд орноо Баруун гарын тэмээчний нутаг одоогийн Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын нутагт байгуулан шашин номын үйлээ эрхэлж байсан, харин харьяа отог шавь нар Сэцэн хан аймгийн Эрх гүний хошуунд нутагладаг байв. Энэ нь Жибзундамба хутагт бол Халхын дөрвөн аймагт тахигдсан блам, шавь нар нь халхын нутагт л нутаглах эрхтэй байсных болно. Чингийн үед Дарьганга бол хааны мэдлийн тусгай бүс нутаг байсан бөгөөд тусгай харуул хамгаалалттай, сүрэгчин ардууд Чингийн төрөөс цалин пүнлүү авдаг, Дарьгангын эрийн гурван наадамд халхчуудыг оролцуулдаггүй, мөн Дарьгангын бөх нарыг Халхын наадамд оролцохыг хориглодог байсан гэх мэт онцлогтой, нэлээд тусгаар байдалтай байсан нутаг юм. Манжийн хааны төмөр сүргийг анх байгуулахад Халх, Баруун Монгол, Өвөр Монголоос ард олныг мал сүргийнхэн хамт авчирч (нутгийн суугуул ардууд ч байсан-Г.Б.) суулгасан учир мэргэн хутагтууд газар газраас ирсэн малчин ардуудын шүтээн нь болж, тэр нутаг орны ардуудын ижилсэлд сүсэг бишрэлийн замаар зохих нөлөө үзүүлсэн нь дамжиггүй.

Үе үеийн Мэргэн хутагтууд хийд орноо өргөжүүлэн хөгжүүлж, хурал номыг дэлгэрүүлж, шавь нараа тэтгэхийн сацуу нутаг орныхоо тахилгат уул усны сангийн судруудыг зохиолгосон нь өдгөө ч тахил тайлга нь хэвээр үргэлжилж нутгийн ардууд тахин шүтсээр байна.

Хутагтын хүрээний хурал номын дэг ёс дахин сэргэж, уламжлал ёсоор хурж байна.

Ашигласан ном зохиол:

Архивын баримт, гар бичмэл

МУҮТА, М-85 Д-1 ХН-416

МУҮТА, М-85 Д-1 ХН-805

МУҮТА, М-85 Д-1 ХН- 944

¹⁴² Дарь овооны сорилгыг амаа Намхай, Халзан хатавчийнхыг Алтангэрэл, Байшинтын хийдийнхнийг Дамиран тэргүүтэй хүчит бөхчүүд тэргүүлэх ба овооны наадамд Намхай аварга 15 жил түрүүлсэн, Ишжамба аваргын төрсөн дүү Пил аварга Алтан дарь овооны наадамд найм түрүүлж байжээ. (Батсүх, Б., Ням-Осор Л. *Монгол бөхийн хөгжилт*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1989, 70.)

МУУТА, М-85 Д-2 ХН-950 2 нуг
МУУТА, М-85 Д-2 ХН-950 21 нуг
МУУТА, М-85 Д-1 ХН-1026,
МУУТА, М-85 Д-1 ХН-1164
МУУТА, М-85 Д-1 ХН-1220
МУУТА, М-85 Д-1 ХН-1227
МУУТА, М-85 Д-1 ХН-1308
МУУТА, М-85 Д-1 ХН-1502
МУУТА, А-6 Д-1 ХН-513
МУУТА, А -74 Д-1 ХН-48
МУУТА, А -74 Д-1 ХН-327
МУУТА, А-74 Д-1 ХН- 329
МУУТА, А -74 Д-1 ХН-508
МУУТА, А -74 Д-1 ХН-513
МУУТА, А-74 Д-1 ХН-662
МУУТА, А-74 Д-1 ХН-701
МУУТА, А-748 Д-1 ХН-152
МУУТА, Х-1 Д-6 ХН-220
МУУТА, Х-179 Д-1 ХН-31
МУУТА, Х-179 Д-2 ХН-82

ТЕГ, тусгай архив Сан 1, Хөмрөг 5, Данс 1, ХН-431:70

МҮНС, Монгол судлал, гар бичмэлийн сан хөмрөг, Богдын шавийн долоон хутагтын уг эх 36/96

МҮНС, Монгол судлал, гар бичмэлийн сан хөмрөг, Богдын уг эх товч 48/96

МҮНС, Монгол судлал, гар бичмэлийн сан хөмрөг, Дээрхийн уг эх, Тэргүүн дэвтэр, 1575/96

IV Богдын сүмбүм дэх залбирал, Зүүн хүрээ Дашчойлин хийд Бурхны шашин соёл судлалын хүрээлэнгийн Ph.D Г.Мягмарсүрэнгээс

Ринчинбадам хутагтын солдэв, Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Дэчинчойнхорлин хийдийн тэргүүн лам Д.Жигмэджамцаас

“Газрыг баригч Дарьганга орны эзэн буяны садан нөхөр сэлтийн илт онол, урилга заллага, хангал наманчлал бүрэн бүрэлдсэний соёрхол тахилга оршвой” Алтан овооны тахилгын судар Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын харьяат А.Гомбоос

“Өгөөмөр ууланд орших суурины эзний соёрхол тахил дуршилаас хагацсан номын чанарт эх орших болой” гэх тахилгын судрыг Зүүн хүрээ Дашчойлин хийдийн лам М.Нандинбаатараас

Ном, өгүүллийн эмхэтгэл, баримтын эмхэтгэл

1. Алтанзаяа Л. Их шавийн отгийн тухай нэгэн мэдээ, *Халхын мэргэн То ван, Эрдэм шинжилгээний цуврал бичиг*, №30, 2005
2. Банзрагч Ч., Сайнхүү Б (эмх). *Монголын хүрээ хийдийн түүх* (эмхтгэл), Улаанбаатар: Соёмбо, 2004
3. Батсүх Б., Ням-Осор Л. *Монгол бөхийн хөгжилт*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1989
4. Билэгсайхан Т. *Дарьганга түүхийн тойм XVII зууны сүүлээс XXI зууны эхэн*, Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2015
5. Бүрнээ Д, Энхтөр Д. *Төвөд Монгол толь*, Улаанбаатар: Цээл эрдэнэ, 2001
6. Билэгсайхан Т. (эмх) Дарьгангын түүхэнд холбогдох баримтууд (Баримт бичгийн эмхэтгэл), Улаанбаатар: Соёмбо, 2020
7. Буджав Д. (эмх) Сүхбаатар аймгийн зарим сүм хийд, лам нарын баримтууд (1933-1937), Улаанбаатар: ТЕГ-ын хэвлэх, 2020
8. Галдан. *Эрдэнийн эрх хэмээх түүх болой*, Улаанбаатар: Соёмбо, 2015
9. Дашбадрах Д. *Монгол Түвэдийн улс төр, шашны харилцааны түүх*, Улаанбаатар: 1998
10. Дашбадрах Д. *Монголын хутагтууд, Монголын хутагтуудын намтрын ойллого (XVII-XX зуун)* Улаанбаатар: 2004
11. *Дээрхийн уг эх*, VII дэвтэр, Улаанбаатар: Соёмбо, 2019
12. Жамсран Л. *Дарьгангын сүрэг хошуу*, Улаанбаатар: Эрдэм, 1994
13. Жамсран Л. *Дарьганга*, Улаанбаатар, 1999
14. Зава Дамдин Лувсандаян. *Их Монгол орон бурханы шашин дэлгэрсэн түүх Алтан дэвтэр*, Төвөд хэлнээс орч. С. Гантөмөр Улаанбаатар: Адмон, 2018
15. Майский И. *Орчин үеийн Монгол (Автономит Монгол XX зууны гараан дээр)*, Орос хэлнээс орч. Ц.Отхон Улаанбаатар: Согоо нуур, 2001
16. *Монголын сүм хийдийн түүхэн товчоо*, Улаанбаатар: Адмон, 2009
17. *Монгол улсын шастир*. II боть. Зарлигаар тогтоосон Монгол улсын шастирын хураангуй” Кирилл бичигт буулгасан. А.Очир, З.Лонжид, Ц.Төрбат, Улаанбаатар: 1997
18. *Монгол улсын шастир* (дэд дэвтэр), Улаанбаатар: Соёмбо, 2006
19. *Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл*. I боть 1206-1910, Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2010
20. Нацагдорж Ш. *Монголын феодализмын үндсэн замнал (Түүхэн найруулга)*, Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1978
21. Нинжбадгар З. *Жибзундамба хутагтын шавийн захиргаа (XVII-XX зууны эхэн)*, Улаанбаатар: Арвин судар, 2014
22. Сэрээтэр Ө. *Монголын Их хүрээ, Гандан хийдийн түүхэн бүтцийн товч (1651-1938)*, Улаанбаатар: Адмон, 2017
23. *Өндөр гэгээний намтрууд оришвой*, Түвэд хэлнээс орч. Ш.Бира, Улаанбаатар: ШУА, 1995
24. Позднеев А.М. *Монгол дахь буддын сүм хийд, лам хуврагуудын аж байдал, лам нар, ард иргэдийн харилцааны тухай тэмдэглэл*, Орос хэлнээс орч. Б. Гэрэл Улаанбаатар: Эрдэм Гэгээрэл Пабблишинг, 2023
25. Пүрэвжав С. *Монгол дахь шарын шашны хураангуй түүх*, Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1978
26. Түмэннаст Я. *Сэтгэлд зүмбэрлэх наран диваажин миний Баяндэлгэр*, Улаанбаатар: 2015
27. Тэрбиш Л. *Төвөд Монгол иж бүрэн толь бичиг*, Улаанбаатар: Соёмбо, 2018
28. Урангуа Ж. *Түүх судлалын жимээр* (Өгүүллийн эмхтгэл), Улаанбаатар: Соёмбо, 2014

29. Хатанбаатар Н. *Монголын хүрээ хийд, лам нар (XVII-XX зууны эхэн)*, Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2018
30. Эрдэнэбилэг Б. (эмх) *Монголын сүм хийдийн түүхээс...* (Баримт бичгийн эмхэтгэл), Улаанбаатар: ТЕГ-ын хэвлэл, 2014
31. *Цахим сурвалж:*
32. Монголын сүм хийдийн түүхэн товчоо төсөл, <https://mongoliantemples.org/en/component/domm/530?view=oldtemplemn>
33. Монголын сүм хийдийн түүхэн товчоо төсөл, <https://www.mongoliantemples.org/mn/monk-mn/568?view=oldtemplemn>
34. Монголын сүм хийдийн түүхэн товчоо төсөл, <https://www.mongoliantemples.org/oralhistorypdfs/L126.pdf>

Orloi Mergen Khutugtu of Ikh Shabi

Abstract:

Under the religious leader of the Khalkhas, the Mongols, the Bogd Jevtsündamba Khutugtu (Tib. *Rje btsun dam pa*, Mong. *Jibjundamba*) also known as Bogd Gegeen, there were tulkus with extensive knowledge, authority, and influence who managed their monasteries, territories, and followers. The main seven Khutugtus with ecclesiastical estates nominated by the Bogd Jevtsündamba Khutugtus (Khal. *Ikh shaviin doloон khutagt*, Mong. *yeke šabi-yin doloγan qutuytu*) and were no possessing seals. These seven Khutugtus were highly renowned for their religious practices. Among them, many distinguished themselves through their scholarly knowledge and political activities, leaving their names immortalized in Mongolia's cultural and political history.

Notable representatives of this esteemed group include the religious and political figure Manzshir Khutugtu Tserendorj (Tib. *'jam dpal Tshe ring rdo rje*, Mong. *Manjusiri qutuytu Čeringdorji*) and the eminent Orloi Mergen Khutugtu. This article explores the history and activities of the Orloi Mergen Khutugtu (Tib. *or-los mer-ken hu-thag-thwo'i*), one of the main Seven Khutugtus of the Ikh Shabi, who was based in the Dariganga region. It highlights how the Orloi Mergen Khutugtu was subject to the Jevtsündamba Khutugtu's authority, established his monastery, was granted a special settlement, and assumed responsibility for the worship of Dari Ovoo.

The research draws upon various sources, including records from the National Central Archive of Mongolia, the Mongolian Studies Manuscript Collection of the National Library of Mongolia, the Special Archives of the General Intelligence Agency, and oral histories from local communities.